www.mongolianminingjournal.com

Эрдсийг эрдэнэст
Ирээдүйг өндөр хөгжилд

Mining the resources
Minding the future




Mining
MONGOLIAN
Journal

# THE MONGOLIAN MINING JOURNAL

Монголын уул уурхай, эдийн засгийн мэдээллийн англи, монгол хэл дээрх анхны сэтгүүл







# THE

Mining MONGOLIAN Journal

Монголын уул уурхай, эдийн засгийн мэдээллийн англи, монгол хэл дээрх анхны сэтгүүл

# MONGOLIAN







# MINING JOURNAL

2008 оны арваннэгдүгээр сараас хэвлэгджээ.















*Хөгжлийг бүгд хүсдэг. Харин хэрхэн хөгжих тухайд олон байр суурь сонсогддог.*
*Тэрхүү төрөл бүрийн үзэл бодлыг ойртуулж, ойлголцож чадвал хөгжилд хүрэх зам дөт болно. Хөгжлийн тухай хамгийн ихээр маргаж байсан цаг үед MMJ мэндэлжээ.*

Үүсгэн байгуулагч Л.Болормаа (2008 он)



Mining
MONGOLIAN
Journal



Уул уурхайн мэдээллийн анхдагч
**ЭХ СУРВАЛЖ**

Монголын уул уурхайн мэдээллийн
**БАЯЛАГ АРХИВ**

Судалгаа, статистик, видео, түүхэн гэрэл зургийн
**НЭГДСЭН САН**



The Mongolian Mining Journal

“Хөгжил” студи

“Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” ТББ

www.mongolianminingjournal.com
info@mongolianminingjournal.com

**7722-0200** **7722-0900**
**7722-2300** **7722-2400**

Эрдсийг эрдэнэст
Ирээдүйг өндөр хөгжилд

The Mongolian Mining Journal нь уул уурхай, эдийн засгийн төрөлжсөн, англи ба монгол хэл дээрх Монголын анхны сэтгүүл.







The Mongolian Mining Journal (MMJ), now nine years old, was the first bilingual journal to provide information on the Mongolian mining industry. It has won accolades from the very beginning, being named, in 2008, by the Mongolian Journalists` Union as the nation`s best journal.

Based on a survey of readers, the Mongolian Journalists' Union re-presented MMJ with the Best Journal Award in 2012.

At present, the MMJ is regularly mentioned at investors` conferences as the first source of Mongolian mining and economic news.

info@mongolianminingjournal.com

Mining the resources
Minding the future

The Mongolian Mining Journal нь аль нэг компани, улстөрч, гадаадын хөрөнгө оруулагчаас хараат бус, бие даасан мэргэжлийн редакци юм. Монгол орны хөгжлийн амаргүй цаг үед бид анхны дугаараа гаргасан. Харин өнөөдөр, Монгол улс хөгжлийн дардан замдаа орсон үед нийтлэлийн бодлогоо улам өргөжүүлэн тэлж яваа урам зоригтой хамт олон юм.

# The Mongolian Mining Journal



Үүсгэн байгуулагч, Л.БОЛОРМАА



Ерөнхий эрхлэгч Б.АЛИГЭРМАА



Ерөнхий санхүүч Г.ЭНХСАЙХАН



MMJ сэтгүүл хариуцсан Орлогч эрхлэгч Н.АРИУНТУЯА



Онлайн хариуцсан Орлогч эрхлэгч Р.ЭРДЭНЭДЭЛГЭР



Англи секц хариуцсан Эрхлэгч T.MUKHERJEE



Маркетингийн албаны дарга Л.БАТБАЯР

Тус сэтгүүлийн редакци нь дэргэдээ “Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” төрийн бус байгууллагыг ажиллуулдаг. Уул уурхай, эдийн засгийн сэдвээр мэргэшин бичдэг сэтгүүлчдийг давтан сургах, танилцах аялал зохион байгуулах зэрэг үйл ажиллагааг тогтмол явуулдаг.

MMJ нь дэргэдээ телевизийн “Хөгжил” студитэй. Энэхүү студийн нэвтрүүлгүүд нь “Хөгжил хөтөлбөр” нэрээрээ үзэгчдийн дунд танил болсон, уул уурхайн салбарын бүхий л үйл ажиллагааг хамарсан мэдээлэл, мэтгэлцээн, танин мэдэхүйн хөтөлбөр юм. Уул уурхайн шилдэг технологиудыг олон нийтэд цувралаар танилцуулсан.

MMJ болон “Хөгжил” хөтөлбөрийг www.mongolianminingjournal.com сайтаас сонирхоно уу.

## The Mongolian Mining Journal-ийн сэтгүүлчид



Г.ИДЭРХАНГАЙ



Э.ОДЖАРГАЛ



Б.ТӨГСБИЛЭГТ



С.БОЛД-ЭРДЭНЭ



Б.РЭНЦЭНДОРЖ

Уул уурхай, эдийн засгийн сэдвээр мэргэшсэн сэтгүүлчдийн баг ажилладаг. MMJ-ийн сурвалжлагчид нь сэтгүүл зүйн шагналыг байнга хүртдэг, мэргэжлийн туршлагатай баг юм.

# Товч ТАНИЛЦУУЛГА

## Mongolian Mining Journal

The Mongolian Mining Journal сэтгүүл 2008 оны арваннэгдүгээр сарын 8-ны өдөр 001 тоот анхны дугаараа хэвлүүлжээ.



MMJ-ийн нийтлэлийн бодлого нь сүүлийн жилүүдэд уул уурхай, эдийн засаг, улс төрийн шийдвэр, үйл явдлын анализ, тойм, судалгаа, хандлага илэрхийлэх чиглэлд түлхүү анхаарч ирлээ.

MMJ-ийн санд хуримтлагдсан Монголын уул уурхайн тухай баялаг мэдээлэл нь манай багийн ул суурьтай, бодитой, мэдлэгтэй мэдээлэл түгээх үндэс болдог.

Монголын Сэтгүүлчдийн эвлэлийн 2008, 2012, 2013, 2016 оны Үндэсний шилдэг сэтгүүлээр тус тус шалгарчээ.

Тус сэтгүүлийн редакци нь нийтлэлийн бодлогын мотогоо *“Хөгжлийг бүгд хүсдэг. Харин хэрхэн хөгжих тухайд олон байр суурь сонсогддог. Тэрхүү төрөл бүрийн үзэл бодлыг ойртуулж, ойлголцож чадвал хөгжилд хүрэх зам дөт болно. Хөгжлийн тухай хамгийн их маргаж байсан цаг үед MMJ мэндэлжээ”* хэмээн эхний дугаартаа 2008 оны арваннэгдүгээр сард нийтэлсэн бөгөөд энэхүү уриа өнгөрсөн есөн жилийн турш сэтгүүлийн нийтлэлийн бодлогын ноён нуруу болж ирэв.



976-77220900
976-77220200

Уул уурхайн салбарын олон улсын хэмжээний томоохон хурлууд, Монголд хөрөнгө оруулагчдын хурлуудыг хилийн чанадаас тогтмол сурвалжлан, Монголын уншигчдад хүртээл болгодог.

Хонконгийн Хөрөнгийн бирж дээр Energy Resources (MMC) компани Монголын анхны IPO хийсэн тухай, Фүкүшимагийн ослын дараа Цөмийн аюулгүй ажиллагааны талаарх Олон улсын атомын энергийн агентлагийн анхны чуулганыг сурвалжилсан зэрэг түүхэн үйл явдлын эх сурвалж болсон туршлага MMJ-ийн багт бий.

Олон улсын уул уурхайн томоохон арга хэмжээнүүдийг цаашид ч газар дээрээс нь сурвалжлан Монголын олон нийтэд хүргэсээр байх бөгөөд зөвхөн сурвалжлага бэлтгэх төдийгүй Монголын уул уурхай, эдийн засгийн мэдээллийн анхдагч эх сурвалж болдгийн хувьд Хөрөнгө оруулагчдын хурлуудад илтгэгчээр оролцох урилгыг байнга хүлээн авдаг.

MMJ-ийн нийтлэлийн бодлого нь сүүлийн жилүүдэд уул уурхай, эдийн засаг, улс төрийн шийдвэр, үйл явдлын анализ, тойм, хандлага илэрхийлэх чиглэлд түлхүү анхаарч ирлээ.










Тиймээс, уул уурхайн судлаач, шинжээч, хуульч зэрэг дотоод, гадаадын нэр хүндтэй аналистууд, судалгааны төрөл бүрийн байгууллагатай тогтмол хамтран ажилладаг.

MMJ сэтгүүл нь Dow Jones-ийн Factiva мэдээллийн сувагтай хамтран ажилладаг бөгөөд тус сэтгүүлд хэвлэгдсэн нийтлэлүүд дэлхийн ажил хэрэгч хүмүүс, байгууллагад энэхүү сувгаар дамжин шуурхай хүрдэг.

factiva
Dow Jones & Reuters

MMJ сэтгүүл нь Dow Jones-ийн Factiva мэдээллийн сувагтай хамтран ажилладаг бөгөөд тус сэтгүүлд хэвлэгдсэн нийтлэлүүд дэлхийн ажил хэрэгч хүмүүс, байгууллагад энэхүү сувгаар дамжин шуурхай хүрдэг.










2010 оноос Mining Journal Awards шалгаруулалтыг бие даан зохион байгуулж байна. Энэхүү арга хэмжээ нь Монголын уул уурхайн салбарын Оны шилдэг үйл ажиллагааг 5 ангиллаар шалгаруулдаг бөгөөд уул уурхайн салбарынхан өргөнөөр оролцож, шалгуур үзүүлэлтээр хүчтэй өрсөлддөг, Монголын нийгэмд нэр хүндтэй, хараат бус арга хэмжээ болжээ.

# ТОМИЛОЛТ

Mining Journal
Mongolian Mining Journal
2010-2017

The Mongolian Mining Journal нь хөрөнгө оруулалт, санхүү, уул уурхай, хanган нийлүүлэлтийн чиглэлийн гадаад, дотоод арга хэмжээнүүдэд идэвхтэй оролцож, сонирхогч талуудыг холбох үр дүнтэй гүүр болдог.

Олон улсын уул уурхайн томоохон арга хэмжээнүүдийг MMJ цаашид ч газар дээрээс нь сурвалжлан олон нийтэд хүргэсээр байх бөгөөд зөвхөн сурвалжлага бэлтгэх төдийгүй Монголын уул уурхай, эдийн засгийн мэдээллийн анхдагч эх сурвалж болдгийн хувьд Хөрөнгө оруулагчдын хурлуудад илтгэгчээр оролцох урилгыг байнга хүлээн авдаг.





## Mongolia Investment Summit-2010

**2010.10.11**
Хонконг






Хонконгт болсон уул уурхайн хөрөнгө оруулагчдын чуулган бөмбөрцөг дэлхийн анхаарлыг Монгол руу эргүүлэв.






## Хонконгийн Хөрөнгийн бирж

**2010.10.11**
Хонконг

Өрнө, дорнын өөр өөр соёлтой хүмүүс энд санхүүгийн хэлээр ярилцаж, хамтран түншилж, харилцан ойлголцож, тасралтгүй урсах их хөрөнгийн урсгалыг түүчээлж байна.





# 2010.10.11
## Хонконг








2010 оны аравдугаар сарын 11-ний үдэд Монголын сэтгүүлчдийн баг Хонконгийн хөрөнгийн биржид анх удаа зочлон, шилэн хаалтны цаанаас арилжаа хэрхэн явагдахыг сонирхож зогслоо. Тэр өдрүүдэд Монголын үндэсний компани анх удаа Хонконгийн бирж дээр хувьцаагаа арилжиж эхэлсэн түүхэн үйл явдал тохиов.











## China Mining Congress & Expo-2010

**2010.11**

Бээжин-Тяньжин

ММJ энэ удаагийн China Mining хурлын Хэвлэл мэдээллийн албан ёсны түнш байгууллагаар хамтран ажиллалаа.









**“Дэлхийн болон Хятадын уул уурхайн сэргэлтэд: Хамтын ажиллагаа, Хариуцлага, Хөгжил 2010”** сэдвийн дор зохион байгуулагдсан энэхүү хуралд Австрали, Канад, Латин Америк, Ази, Африк, Хятад зэрэг дэлхийн 40 гаруй орны төлөөлөгч, хөрөнгө оруулагчид оролцов.

## Mines and Money

**2011.03**

Хонконг



**Mines and Money буюу хөрөнгө, орд** гэсэн сэдэв нь Монголын хувьд түлхүүр ойлголт юм. Яг ийм Монголд анхаарал хандуулсан хурал Хонконгт мөн болох тухай Монголын Бизнес Зөвлөлийн Гүйцэтгэх захирал Жим Дуэр онцлон тэмдэглэлээ.



## ОХУ-д хийж буй Ерөнхий сайдын албан ёсны айлчлал

**2010.12**

ОХУ, Москва-Санкт Петербург



Гэрэл зургийг Б.Оджаргал /Москва/

Хэн хэнийхээ эрх ашгийг хүндэтгэсэн, эдийн засаг, бизнесийн өнцгөөс асуудалд хандсан яриа хэлэлцээрийн үр дүнд нийт 11 баримт бичгийг үзэглэсэн юм. Хэлэлцээрийн төгсгөлд ноён Путин “Тохир-ла” хэмээн монголоор хэлж, Ерөнхий сайдтай гар барьсан нь айлчлалын үр дүнд сэтгэл ханамжтай байгаагийн илрэл буй за.

ОХУ-д албан ёсны айлчлал хийж байгаа Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболд тус улсын Засгийн газрын дарга В.В.Путинтэй ганцаарчилсан уулзалт болон өргөтгөсөн хэлэлцээр хийлээ.





## Asia Mining Congress

**2011.04**

Сингапур




Бага хурал Азийн хэмээх тодотголтой хэдий ч уул уурхайн салбарынхны хараагаа бэлчээж эхэлсэн нөөц баялаг бүхий цөөнгүй орон энэ тивд оршдог учир Asia Mining Congress-т дэлхийн өнцөг булан бүрээс ач холбогдол өгч, зорин ирдэг юм.



## Олон улсын атомын энергийн агентлагийн чуулга уулзалт

**2011.06**
Австри. Вена

Агентлагийн гишүүн 151 орны цөмийн энергийн салбарын мэргэжилтнүүд энд хуран чуулсан юм.



Фүкүшима Дайчи атомын цахилгаан станцад гарсан ослын дараа анх удаа олон улсын хэмжээнд цөмийн эрчим хүчний аюулгүйн бодлогыг хэлэлцсэн нь энэ.



## Mines and Money




**2012.03**
Хонконг





Mongolian Mining Journal нь **Mines and Money Hong Kong** хөрөнгө оруулагчдын чуулга уулзалтын Мэдээллийн түншээр жил бүр оролцож, хурлаас бэлтгэсэн сурвалжлагыг уншигчдадаа хүргэж байна.

## “Рио Тинто” компанийн Австрали дахь зарим уурхайтай танилцав





**2012.10.9**

Австрали. Нью Саут Уэльс муж



Австралийн Нью Саут Уэльс мужийн баруун өмнөд нутаг дахь Нортпаркесийн алт, зэсийн гүний уурхайн үйл ажиллагаатай танилцлаа.







Уул уурхайн үйлдвэрлэлээр баруунаа гүйцэхгүй ч өөрийн гэсэн үйлдвэрлэлтэй. Нью Саут Уэльс мужид 60 уурхай бий. Тэдний 29 нь далд, 31 нь ил уурхай бөгөөд 29-ийг нь томоохон гэсэн тодотгол дагана.

## Ерөнхий сайдын БНХАУ-д хийж буй албан ёсны айлчлал



**2013.10.22**

БНХАУ, Бээжин



Хятадын Дандонг, Чиньжоу, Чиньхуандао, Тяньжин, Хуанхуа зэрэг долоон боомтыг ашиглан Монгол улс далайд гарах шинэ боломж нөхцөл хоёр талын гэрээ хэлэлцээр шинэчлэгдсэнээр бүрдэх юм. Ерөнхий сайдын айлчлал энэ бүхэнд томоохон түлхэц өгөв.

## Bauma 2013

In April, 2013 The Mongolian Mining Journal attended the bauma trade fair in Munich, Germany.

**2013.04.18**

ХБНГУ. Мюнхен












Германы Мюнхен хотноо уул уурхай, барилга, дэд бүтцийн салбарын дэлхийн 1000 орчим компани үзэсгэлэнгээ гаргасан юм. Bauma нэрээрээ олон улсад танил болсон энэхүү үзэсгэлэн яармагийн арга хэмжээ 50 жилийн түүхтэй. Дөрөвдүгээр сарын 18-ны өдөр Country Special Mongolia буюу “Монголын өдөр” зохион байгуулагдсан юм.

## АПЕК-ийн уулзалтад Монгол улс анх удаа зочин орны статустай оролцов

**2014.11.8**

БНХАУ, Бээжин






Форумын өмнө Ц.Элбэгдорж БНХАУ-ын дарга Си Жинпинтэй уулзаж, зөвхөн энэ жил гэхэд хоёр орны төрийн тэргүүн найрсаг дотноор тав дахиа ийнхүү уулзаж байгааг тэмдэглээд, Дээд түвшинд яригдсан хэлэлцээрүүдийг нэн даруй ажил хэрэг болгох талаар санал нэгтэй байгаагаа тэмдэглэсэн билээ.

## Канадын уул уурхайн салбарын туршлагатай танилцав

**2014.05.10**
Канад, Ванкувер

Канад байгалийн нөөцөөр баялаг орон. Туулсан туршлага, алдсан алдаа, авсан сургамж бүхнээ хуваалцахаар богино хугацааны сургалтын хөтөлбөрийг Монголын төлөөлөгчдөд тусгайлан зориулж гаргасан юм. Канадын олборлох салбарын үйлдвэр болон хөгжлийн олон улсын хүрээлэн /CIIEID/-гийн урилгаар Канадын уул уурхайн салбарын туршлагатай танилцах багт төрийн болон төрийн бус байгууллага, их сургууль, судалгааны байгууллага, хэвлэл мэдээллийн салбарыг төлөөлсөн 9 хүн багтжээ.







Нью Афтон нь Оюутолгойд сонгосон блокчлон олборлох технологиор олборлолт явуулж буй алт зэсийн уурхай. Бас Оюутолгойн ТЭЗҮ-ийг хийж буй АМЕК уурхайн дизайныг хийсэн. Түүнчлэн нийгмийн хариуцлагын чиглэлээр Канаддаа хамгийн сайн туршлагатай гэгддэг компаниудын нэг “Нью гоулд” компани уурхайг эзэмшдэг. Эдгээр нь Монголын баг Нью Афтоныг үзүүлэх шалтгаан болсон биз ээ.



## “Торгоны зам”-ыг тодруулахуй

**2014.09**
Шинжаан-Уйгар. Өрөмч






БНХАУ-ын дарга Си Жинпины санаачилгаар шинэ цагийн “Торгоны замын эдийн засгийн бүс”-ийг байгуулахаар олон улсад өргөн цар хүрээтэй сурталчлах кампанит ажлуудын нэг нь энэхүү арга хэмжээ байсан юм.

Эртний худалдааны энэхүү замыг өнөө цагт сэргээхэд Хятад улс хөгжлийн бодлогоо чиглүүлж, 40 гаруй орны 3 тэрбум хүн амтай бүс нутгийг хамрах томоохон амбицтай төслийг хэрэгжүүлэх гэж байна.

## Sustainable Development in the Minerals Industry

**2015.07.15**
Канад, Ванкувер

The Mongolian Mining Journal нь уул уурхайн салбарт хөрөнгө оруулагчдын хурал уулзалт, үзэсгэлэнгийн арга хэмжээг тогтмол сурвалжилж ирсэн бол энэ удаа эрдэс баялгийн салбарт гарч буй бодлогын шинэ хандлагад төвлөрсөн SDIMI хурал оролцоод ирлээ.







Дэлхий дахинаа уул уурхайн том төслүүд эрсдэлд орох, зардал анх төлөвлөснөөс нэмэгдэх хандлага газар аваад байна. Ийм үед "Тогтвортой хөгжил"-ийн шинэ менежментээр компанийн захирлууд, Засгийн газрууд ажиллах ёстой гэсэн уриалгыг SDIMI дахин гаргав.

## Засгийн газрын бодлого, эрдэмтдийн судалгааны зөв хослол

**2016.04.23**
Малайз. Куала Лампур




Голдуу уул уурхайн салбарын хөрөнгө оруулагчдын хурал уулзалт, үзэсгэлэнгийн арга хэмжээг сурвалжилж ирсэн The Mongolian Mining Journal энэ удаа Малайзийн стратегийн чухал салбар дал модны аж ахуйд төвлөрсөн танилцуулгад оролцоод ирлээ.





## Баялгийг хөгжил болгох эсэх нь баялгийн засаглалаас хамаарна

**2016.03.28**

Тайланд, Бангкок

Монголд Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОҮИТБС) сайн хэрэгжиж буй боловч нөгөө талаар “голланд өвчний” шинж тэмдэг хүчтэй мэдрэгдэж буй орнуудын дунд Монгол зүй ёсоор орчихсон яваа юм. Энэ үйл явц нь бид баялгаа сайн удирдаж чадахгүй байгааг нотолно. Ийм цаг дор эрдэс баялгийн салбарын олон талт асуудлыг хэрхэн удирдах талаарх  семинар Бангкок хотноо боллоо.





## “Эдийн засгийн коридор”-ын замаар хийсэн тэмдэглэл



**2016.09**

БНХАУ. ӨМӨЗО-ы Эрээн хот

Газар зүйн байршлын давуу талаа ашиглан дэлхийн хоёр том зах зээл Орос, Хятад улс, цаашлаад Ази, Европ тивийг холбосон эдийн засаг, худалдааны хамгийн дөт зам байх боломж манай улсад бий. Монгол, Орос, Хятад гурван улс “Эдийн засгийн коридор” байгуулахаар төслүүд эхнээсээ тодорч буй энэ цаг үед  уг санаачлага бодитоор хэрэгжих боломжтой...

## Монголын экспортын нүүрсний замаар хийсэн тэмдэглэл

**2017.04**

Ханги мандал  боомт -Бугат хот /БНХАУ



## Тэнгэр уулын тэмдэглэл

**2016.11.11**
Киргиз, Бишкек хот





Очиж үзээгүй ч олонтаа бичиж байсан тэрхүү орон зайд хүрч төсөөлөл, бодит байдлыг харьцуулах содон мэдрэмжид сэтгүүлчийн томилолтын хамгийн гоё “амт” байдаг. MMJ-ийн хуудаснаа хэдэнтээ бичсэн Хятадын шинэ Торгоны замын нэг хэсэг, Ази-Европ тивийг холбосон транзит тээврийн Монголтой өрсөлдөхүйц чиглэл, дэлхийн алтны гурав дахь том орд Кумторын төслийг 20 жил хэрэгжүүлж буй Киргиз орны өнөө цагийн хөгжил дунд алхаж, дэргэдээс нь тольдох завшаан тохиосон билээ.



## Монголын сэтгүүлчид New-Acland уурхайтай танилцлаа

**2017.04.22**
Австрали. New Acland-ын нүүрсний уурхай



Квийнсланд мужийн Сурат, Боуэны сав газраас олборлож буй метан хийн экспорт, байгаль орчны холбогдолтой асуудлууд орон нутагт хурцаар хөндөгдөж байгаа учраас сэтгүүлчид энэ чиглэлийн мэдээ, сурвалжлагыг түлхүү бэлтгэж буй аж.



# УУРХАЙН СУРВАЛЖЛАГА

Mining Journal

Mongolian Mining Journal

2009-2017

Газар дээрээс нь хийсэн сурвалжлага тус сэтгүүлийн нийтлэлийн бодлогод тэргүүлэх байр суурьтай. Монгол орны өнцөг булан бүрт өрнөж буй бүтээн байгуулалтын талаар анхны өдрөөс нь, түүхэн цэгээс нь эхлэн тогтмол мэдээлж ирэв. Оюутолгой, Ухаахудаг, Зүүн, Баруун Цанхийн уурхайн он дараалын товчооныг бид газар дээрээс нь бичиглэжээ.




**2008.11**
Дорнын цэнхэр жимээр...

**2011.07**
Ухаахудаг ба “монгол брэнд”

**2011.10**
Бодлого үгүйлэгдсэн боомт

**2012.02**
Их хүйтрэл ба уурхайчдын тэмцэл

**2010.10**
Тэнгэр говьд нүргэлэн буй бүтээн байгуулалт

**2013.06**
Эрдэнэсийг эзэгнэхүй

**2014.06**
Цагаансуваргын эгээгтэй өдрүүд

**2014.05**
Хүнд нөхцөлд хүчийг үзэж буй монгол уурхайчид

**2014.08**
Тосон Заамар “ногоон Заамар” болох цаг

**2016.11**
Нэг үнэтэй “Тавантолгойн брэнд” монголчуудад ашигтай

## Ураны мөрөөдлөөр дахин амьсгалсан Дорнын цэнхэр жимээр (2008.11. MMJ № 001)



“Хан Ресорсез”-ийн талбай. Хоёрдугаар хүдрийн биет газрын гадаргуугаас ойрхон 170 метрийн гүнд оршдог бөгөөд одоогоор газрын гүний усыг шавхаагүй байгаа нь.

**2008.11.** MMJ № 001



Гэрэл зургийг Б.Ундрал

Монгол орны ураны хамгийн их нөөцтэй газар нутаг Дорнод аймагт байдаг. 1973 онд БНМАУ-ЗХУ хооронд ураны хайгуул хийх Гэрээ байгуулж, улмаар 1981 онд ЗХУ-ын тал ордын нөөцийг тодорхойлсон. Албан бус баримтаар оросууд 1996 он хүртэл ойролцоогоор 550 мянган тонн уран эндээс олборлосон гэдэг.

“Хан Ресорсез” ХХК-ийн хайгуулын ажил гурван жилийн турш үргэлжилж, нийт 10 сая ам.доллар зарцуулсан. Энэхүү дээжийн агуулахад хайгуулын үр дүн хадгалагджээ.

**2009.03. № 005**

## Их эзний шарил эх нутагтаа амгалан оршму

(2009.03. MMJ № 005)



Бурхан Халдун уулын оргил Тэнгэрийн Овооны зургийг нисдэг тэрэгнээс авсан байдал, далайн түвшнөөс 2362 метрийн өндөрт.



Орхоны хөндий дэх Билгэ хааны бунхан орчим.

Найман зууныг элээсэн дэлхийн тааврын тайлагдашгүй чагтыг чухамдаа Монголын хэсэг эрдэмтэн олж эргүүлсэн юм.

Их эзэн хааны онгон судлалын ажлыг тулгар бичгийн судалгаа, газрын судалгаа гэсэн хоёр чиглэлээр тус экспедицийнхэн хийжээ. Нийтдээ экспедицэд 25 орчим эрдэмтэн ажилладаг. Монголын хэвлэлд анх удаа энэ сэдвээр дэлгэрэнгүй нийтлэгджээ.

## 2009.08. № 010





### Үрчгэр уулсын өчил (2009.08. MMJ № 010, Цагаан хад)

Иш, нутгийнхныхаа чадан ядан амьдарч явааг хараад их говийн үрчгэр уул би өмнөөс нь сэтгэл өвдөж, өр зүрхэндээ ингэдэг ч болоосой, тэгээсэй билээ хэмээн бухимдах юм.

Юу эсийг бодох вэ, цагийн уртад. Үрчлээтэн тогтсон боржин уулсын тэргүүнийг ажаарай даа. Говийн бор уулсын гайхамшигт тогтцыг гэрэл зургийн хальсандаа таануус буулгаад л явчихдаг шүү. Өчил үгийг минь хэрвээ гүйцэд сонсдогсон бол өвгөн буурал гарц хэлээд өгчих юмсан.

**Хязгаар нутагт тань төр, засгийн том бодлого үгүйлэгдэж байна. Энүүгээр хэрэв өнгөрвөл үрчлээт уулсаа нэг тогтож хараарай. Өчил үг нь салхин чимээнд сонстох вий.**

## 2011.10. № 036








### Бодлого үгүйлэгдсэн боомт

(2011.10. № 036)

Улаанбаатар хотоос 900 гаруй км зам туулж, Шивээхүрэн боомтод ирэв.

Шивээхүрэн боомт Шинжаан Уйгурын өөртөө засах орноор дамжин Төв Азийг чиглэх гарц болох боломжтой. Хэзээ нэг өдөр ашигт малтмалын нөөц дуусна. Баялаг барагдлаа гээд зэлүүд газар үлдэх бус, боомт дагасан том худалдааны хот суурин босчихвол нутгийн иргэдэд, цаашлаад улс орны эдийн засагт өгөөжтэй.

## 2011.08. № 034

### Жижиг тодотголтой ч ихийг бүтээсэн уурхай

(2011.08. № 034)

“Анхандаа хүн хүч цөөн байсан болохоор уурхайн тосгоноо өөрсдийн улаан гараар байгуулж байлаа” хэмээн уурхайн анхны дарга, өдгөө 70 гаруй настай С.Хүүхэнжав гуай дурсаж сууна. “Одоогийн энэ наймдугаар ам дээр ганц машин эргэх зайтай газраас гар аргаар нүүрс ачиж байлаа. Тэдэлгүй үйлдвэрийн технологийн аргаар тэсэлгээ хийж нүүрсээ олборлох болсон. Анх цөөхөн хэрэглэгчтэй, жилдээ 15 мянган тонн нүүрс олборлодог байв. 1966 онд улсын уурхай болоход нэг экскаватор, ганц трактор, дөрвөн гэртэй байлаа. Тэр үед зэлүүд онгон талд тэсэлгээ хийж байсан...



“Жижиг” Тавантолгой.

## 2012.02. № 040

### Их хүйтрэл ба уурхайчдын тэмцэл

(2012.02. № 040)

Хэдийгээр Багануурыг зүүн бүсийн хамгийн хүйтэн газар гэдэг ч энэ жилийн тухайд өмнөхтэй харьцуулахын аргагүй хүйтэн өвөлжиж. Тоног төхөөрөмжүүд нь түрүүчээсээ хөлдөж, эвдэрч, “жагсаал”-аас гарах дөхжээ. Тэсгим хүйтэн шөнөөр экскаваторын тэс хөлдүү шанаган дээр тэгнэн хэвтчихээд гурваас дөрвөн цаг гагнуур хийж байгаа уурхайчныг харсан хүнд өрөвдөх, бас бахархах сэтгэл эрхгүй төрөх биз ээ.





## 2012.03. № 041

### Металлургийн цогцолбороо цаг алдалгүй байгуулъя

(2012.03. № 041)

Дарханы Төмөрлөгийн үйлдвэр



Том цогцолбор барих нь зөв юм гэсэн ерөнхий зүйл ярьсаар байтал стратегийн гол түүхий эдийн нөөц дуусч мэдэхээр болжээ.



## 2013.02. № 052

### Уул уурхай ба нутгийн хүмүүс

(2013.02. № 052)



Уул уурхай хөгжихтэй зэрэгцэн нөлөөллийн бүс буюу Ханбогд, Цогтцэций, Баян-Овоо зэрэг сумдад өрнөж буй бас нэг том ажил бол байгаль орчин, соёлын өвийн асуудал. Эдгээр сумдын нутгаар явахад археологи, палеонтологи, угсаатны зүйн судалгааны хүмүүстэй элбэг таарах аж.

## 2009.12. № 014

### Түүхий нүүрсийг “хорхог” болгох нүргээн

(2009.12. № 014. Ухаахудаг)



Үүрийн цолмон анивчсаар бүдгэрч, гэгээ татахын алдад “Тавантолгой” нисэх буудалд газардлаа. Говьд өссөн хэрнээ үүр цайхдаа ийм үзэсгэлэнтэй байдгийг ер анзаараагүйгээ гайхав. Өргөн талын захаас зэсэн өнгөт улбар наран туяагаа цацсаар аажмаар мандах нь үлгэрийн мэт сайхан харагдана. Наран мандахаасаа жаргах хүртлээ говь нутагт илчээ харамгүй өгдөг нь асар их баялагтай байхын үндэс ч юм уу гэж бодогдлоо...

**“Алсаас сонсох, айлчилж ирээд нүдээр үзэх хоёр хол зөрүүтэй байдаг” гэдэгтэй УИХ-ын гишүүд санал нэгдсэн юм.**






Энэхүү Нүүрс баяжуулах Монголын анхны үйлдвэрийн шав дээр ирэх жилийн 12 дугаар сард үйлдвэр ажлаа эхлүүлж, удам талд дуугаа хадаахыг тэмдэглэжээ.

## 2011.07. № 033

### Ухаахудаг ба “монгол брэнд”

(2011.07. № 033)

Нүүрсээ угааж, баяжуулаад экспортлохын үнэ цэнийг Ухаахудагийн шинэ үйлдвэр нээж өгч байна. Монгол инженерүүдийн ур ухааныг дэлхий хүлээн зөвшөөрөх цаг ирлээ.



Говь нутаг үйлдвэржиж эхэллээ. Тодруулж хэлбэл уул уурхайн шинэ цагийн үйлдвэрүүдийн эхлэлийг Ухаахудагийн Нүүрс баяжуулах үйлдвэр тавилаа. “Монгол”-оор овоглох коксжих нүүрс дэлхийн “хар алт”-ны зах зээлийн ширүүн өрсөлдөөн дунд орж, өөрийн үнэ цэнээ ахиулах асар том боломжийг Нүүрс баяжуулах үйлдвэр нээж байгаа юм.



## 2011.10. № 036

### Удам говьд илч түгээх бүтээн байгуулалт (2011.10. № 036)

Говь намартаа жаргалтай гэдэг. Намрын зөөлөн шаргал нар ээсэн есдүгээр сарын 24-ний өдөр Ухаахудагийн хөндийд цахилгаан станцын нээлтийн ёслол болсон юм.





“Энержи ресурс” компанийн захиалгаар Ухаахудагт барьсан Цахилгаан станцын ерөнхий гүйцэтгэгчээр “М-Си-Эс интернэйшнл” ХХК ажиллажээ. Энэхүү үндэсний томоохон бүтээн байгуулалтын төсөлд эрчим хүч, барилга угсралтын 80 гаруй компанийн 1500 орчим инженер, техникийн ажилтан оролцсон бөгөөд тэд эрвийх дэрвийхээрээ зүтгэсний эцэст их ажлын ард гарчээ.



Мандалговиос Тавантолгой хүртэл 902, Тавантолгойгоос Оюутолгой хүртэл 400 орчим тулгуур баганыг тус бүр 250-350 метрийн зайтайгаар босгоно гэдэг тийм ч амар ажил биш. Гэхдээ “М-Си-Эс Интернэйшнл” болон бүтээн байгуулалтад хамтран оролцож байгаа Монголын үндэсний компаниуд энэ бүхнийг бүтээх учиртай.



## 2013.08. № 058

### Заамар сумын нутагт орших “Монголын уул уурхайн үндэсний олборлогч” ХХК-ийн Бага Хайлаастын алтны шороон ордын уурхай

(2013.08. № 058)



## 2013.06. № 056



Зэс боловсруулах
**“ЭРДМИН”** үйлдвэр

### Эрдэнэсийг ээзгнэхүй

(2013.06. № 056)

Ил уурхайд нэвтрүүлэх шинэ технологи Эрдэнэтийн инженерүүдийн хүчийг сорих шинэ талбар. 35 жил бэлтгэсэн инженерүүд нь эрийн цээнд хүрсэн эсэхийг энэ технологи үйлдвэрлэл дээр харуулна.







Эрдэнэтийн хаягдал хүдэр дээр боссон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг “Эрдмин” үйлдвэрийн үйл хэрэг амжилттай байна. Удахгүй дараагийн бүтээгдэхүүнээ гаргана гээд үйлдвэрийн ажилчид ч итгэл зориг төгс байна.

## 2014.08. № 070

### Тосон Заамар “ногоон Заамар” болох цаг

(2014.08. № 070)

**Г**энэтийн” тодотголтой 68 хувийн татвар, “бичил уурхайчид” гэх шинэ нэртэй “нинжа” нар, сум орон нутгийнхны үл ойлголцол, төрийн элдэв дарамт шахалт гээд олон саад бэрхшээлийг туулан унахдаа унаж, босохдоо босч явсаар өдийг хүрсэн Заамарын алтны компаниудын үйл ажиллагаа нэг үеэ бодвол сэргэж байна гэсэн таатай мэдээ гарах болсон.

Гэхдээ бодит байдал дээр энэ бүхэн ямар байгааг сурвалжлахаар The Mongolian Mining Journal-ийн баг наймдугаар сарын 20-ны өдөр Төв аймгийн Заамар сумыг зорилоо.





## 2014.05. № 067



### Хүнд нөхцөлд хүчийг үзэж буй монгол уурхайчид

(2014.05. № 067)

Хүрэх газар маань Дархан хотоос хойш 50 км-т орших Сэлэнгэ аймгийн Дулаанхаан тосгон. Дархан өнгөрөөд утаа татсан харагдана. Сибирьт ойн түймэр гарч, утаа нь орж ирсэн нь энэ. Цагаан хаалга өртөө нь Сэлэнгэ аймгийн Шаамар сумын Дулаанхаан тосгонд байрлах, 80 гаруй км үргэлжилсэн Баянголын төмөр замын УБТЗ-ын гол төмөр замтай нийлэх зангилаа өртөө.

## 2014.07. № 069



Mongolian Mining Journal-ын сурвалжлах баг Сэлэнгэ нутагт төмрийн хүдрийн олборлолт явуулдаг Баянголын уурхайг сурвалжлахаар зорьсон юм.





## 2014.06. № 068

### Цагаансуваргын эгзэгтэй өдрүүд



Стратегийн ач холбогдол бүхий ордуудын нэг Цагаансуваргад төр өмчлөлөө тогтоох эсэхийг УИХ-аар ид хэлэлцэж эхлэх үед The Mongolian Mining Journal-ийн сурвалжлах баг Цагаансуваргыг дахин зорилоо.



Жил хүрэхгүйн өмнө Цагаансуваргын ордыг зорьж, тэдний 7.2 мВт-ын дизель станцуудын суурилуулалтын ажлыг сурвалжлах явцдаа үндэсний мэргэжилтнүүдийн гараар босч буй их бүтээн байгуулалтыг хараад бахадсан билээ. Энэ бол Дорнын их говьд сүндэрлэн буй Цагаансуваргын зэс-молибденийн уулын баяжуулах “Мега төсөл”-тэй танилцсан анхны сэтгэгдэл байлаа.

## Уул уурхайн салбарынхны тогтож уншдаг сэтгүүл болсонд бид талархдаг

МУУҮА-ийн Гүйцэтгэх захирал **Н.Алгаа:** (2013)

Монголын Уул уурхайн үндэсний ассоциаци 2001 оноос “Эрдэс баялгийн мэдээ” сонин гаргадаг байсан юм. Гэхдээ бид уул уурхайн салбарт сониноос илүү сэтгүүл хэрэгтэй юм байна, энэ нь шинжлэх ухааных биш, бизнесийн чиглэлийн, тэр дундаа хөрөнгө оруулагчдад, бизнес эрхлэгчдэд илүү хэрэгцээтэй гэж үзэж, хэвлэл мэдээллийн олон хүмүүстэй уулзаж байлаа. Тэгээд Л.Болормаа эрхлэгчтэй гурав дөрвөн удаа уулзсан санагдана. Хэвлэл мэдээллийнхэн Ассоциацийн харьяаны сэтгүүл болбол нэг талыг баримтлахаас гадна чөлөөт биш байдлаар гарч болзошгүй гэж тухайн үедээ жаахан болгоомжилж байсан л даа.

Ингээд Уул уурхайн ассоциацийн Чадавхийг бэхжүүлэх төсөл дээр ажиллаж байсан Э.Содонтогос, Л.Болормаа бид гурав ярилцаж байгаад уул уурхайн салбарт хэрэгтэй, бие даасан, чөлөөт сэтгүүл байх нь зөв юм байна гэж тогтсон юм. 2008 онд Mongolian Mining Journal сэтгүүлийн хамгийн анхны №001 дугаарыг олон улсын хөрөнгө оруулагчдын “Дисковер Монголиа-2008” чуулга уулзалтаас санхүүжүүлэн гаргаж байлаа. Тухайн үед салбар дагнасан ийм сэтгүүл тун цөөхөн байсан. 2008 оны арванхоёрдугаар сард Mongolian Mining Journal шилдэг сэтгүүлийн шагнал авч байсныг би санаж байна.

Түүнээс хойш энэ сэтгүүл англи, монгол хэл дээр бие даан гарч, уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа томоохон хөрөнгө оруулагчид, бизнес эрхлэгчид, судлаачид, бодлого боловсруулагчдын анхаарч, тогтож уншдаг сэтгүүл болсонд Монголын Уул уурхайн үндэсний ассоциаци талархаж явдаг.

“Дисковер Монголиа” чуулга уулзалт зэрэг уул уурхайн хөрөнгө оруулагчдын томоохон арга хэмжээнүүд дээр Mongolian Mining Journal байнга хамтарч ажиллаж ирлээ. Мэдээж Монгол улсад уул уурхайн салбар хурдацтай хөгжиж байгаа төдийгүй дэлхийн анхаарлын төвд орсон учраас маш олон арга хэмжээ зохион байгуулагддаг болсон байна.

Тэр бүхэнд сэтгүүл оролцож, салбарынханд мэдээллээ хүргэдэг. Сүүлийн үед Ашигт малтмалын тухай хуулийн хэлэлцүүлгийг ч өргөн хэмжээгээр явуулж ирсэнд бид бас талархаж байгаа. Үүнээс гадна сэтгүүл уул уурхайн салбарын шилдгүүдийг бие дааж гурав дахь жилдээ шалгаруулдаа. Цаашид энэ шалгаруулалт илүү чамбай болох байх. Шалгаруулалтад орохын тулд компаниуд нэлээд бэлтгэлтэй, бодож оролцдог болно гэдэгт итгэж байна.

## Mining Journal сэтгүүлд байр сууриа илэрхийлж чадсан хүнийг би уул уурхайн салбарын хүн, энэ салбарын оролцогч гэж ойлгодог

Төмөр замын инженерүүдийн холбооны Ерөнхийлөгч **Л.Пүрэвбаатар:** (2013)

Хэвлэл мэдээлэл нийгмийн санаа бодлыг бүрдүүлдэг гэж ярьдаг. Нийгмийн оюун санаа гэдэг маш хүчтэй зүйл. Медиа салбар нь өндөр хөгжөөд нийгмийн оюун санааг нэгтгээд, уул уурхай руугаа зөв хаях юм бол хөгжүүлээд л ирнэ. Хэвлэл мэдээллээр дамжуулан асар их ойлголт авчихсан хүмүүс хөгжлийн чиг хандлагатай холбоотой бодитой зүйл ярьж байгаа улстөрчдийн төлөө кноп дарж эхэлнэ. Энэ хүн уул уурхайн салбарыг илүү ойлгодог, илүү мэдээлэлтэй, зөв байр суурьтай юм байна. Харин энэ улстөрч уул уурхайд өөрийн амбицийг тулгаж байгаа юм байна гэдгийг нийгэм ойлгоод эхэлбэл кноп зөв эргэнэ. Нийгмийн санаа бодлыг, мэргэжлийн хүмүүсийн арга туршлагыг уул уурхайн салбар руу нь татан оруулаад өгөх юм бол хэвлэл мэдээллийн үүрэг роль, ач холбогдол нь түүнд байна гэж би ойлгодог. Мэргэжлийн сэтгүүлд гарч байгаа мэргэжлийн хүмүүсийн байр суурь, судалгаа шинжилгээний үр дүнд тэр салбарын хөгжлийн чиг хандлага зөв тогтдог. Хэвлэл мэдээлэл ийм том үүрэг, ач холбогдол, байр суурьтай юм.

Тийм арга ухаан өндөр хөгжилтэй орнуудад ч байна. Майнинг журнаал шиг төрөлжсөн сэтгүүлээр дамжаад бодож сэтгэдэг, судалж тогтоодог зүйлийг нийгмээрээ хиймээр байна.

Би төмөр замын салбарт ямар шинэ стандарт, техник технологи гарав гэсэн мэдээллийг Майнинг журнаалаас авч чадахгүй. Гэхдээ төмөр замын холбогдоод байгаа салбар болох уул уурхайн тухай мэдээллийг авч чаддаг. Би хэвлэлийн аналитик хүн биш. Гэхдээ уншигчийн хувьд бодлоо хэлэхэд, мэргэжлийн хүмүүс, эсвэл энэ салбарын оролцогч хүмүүсийн байр сууриа Майнинг журнаал сэтгүүлд маш сайн гардаг. Улстөрчид мэргэжлийн салбарт том дуугарч чадахгүй л дээ.Тиймээс танай сэтгүүлийг улстөрчид тойроод байх шиг санагддаг. Энэ сэтгүүлд яриа өгч, байр сууриа илэрхийлж чадсан хүнийг би уул уурхайн салбарын хүн, энэ салбарын оролцогч гэж ойлгодог. Тиймээс ч Майнинг журнаал сэтгүүлийг Монголын ард түмний хэрэгцээ болоосой гэж хүсдэг.




## Өөрийн гэсэн өнгө төрх, дуу хоолойтой сэтгүүл

“Монголын Алт” компанийн Үйлдвэрлэл, төслийн хэрэгжилт эрхэлсэн Дэд ерөнхийлөгч **Г.Цогт:** (2013)

Mongolian Mining Journal өөрийн гэсэн өнгө төрх, дуу хоолойтой сэтгүүл. Аль ч улс оронд, ялангуяа уул уурхай хөгжиж байгаа улс оронд салбарын ийм сэтгүүлүүд байдаг. Монголын уул уурхайн салбарт ийм журнаал бий болж, салбарын компаниудын үйл ажиллагаа, арга туршлагыг хооронд нь танилцуулж, уурхайчдын санаа бодлыг хуваалцаж, олон нийтэд хүргэхэд чухал үүрэг гүйцэтгэж байгаад талархалтай явдаг.

Mongolian Mining Journal сэтгүүлийн нийтлэлийн бодлого өргөн, элдэв улс төрийн өнгө аяс цухалздаггүй, бодит байдлыг байгаагаар нь гаргаж тавьдгаараа онцлог. Уншигчийн хувьд Монголын уул уурхайн салбар дахь үйлдвэр аж ахуйн газрууд, гадны хөрөнгө оруулагчдын үйл ажиллагаа, шинээр оруулж ирж байгаа техник технологийн мэдээллийг энэ сэтгүүлээс авч чаддаг. Цаашид зөвхөн салбарын хүрээнд биш, нийт ард түмний хэмжээнд, төр засгийн удирдлагуудын хэмжээнд мэдээлэл авдаг сэтгүүл болж өргөжөөсэй гэж хүсч байна. Монголын уул уурхай 90 гаруй жилийн түүхтэй том салбар. Үе үеийн уурхайчдын хийж бүтээж ирсэн түүх, дурсамж, ажлын туршлагыг залуу хойч үеийнхэнд үлдээх чиглэлээр ажиллаасай гэж уншигчийн хувиар хүсдэгээ энэ дашрамд хэлэх байна.

Эцэст нь Mongolian Mining Journal сэтгүүлийг эрхлэн гаргаж байгаа уран бүтээлчид, нийт хамт олонд “Монголын Алт” компанийн нийт ажиллагсдын өмнөөс болон хувиасаа ажлын их амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

## Уул уурхайн тухай зөв ойлголтыг түгээж байна

Ш.Отгонбилэгийн нэрэмжит Технологийн сургуулийн захирал, доктор, аж үйлдвэрийн гавьяат ажилтан **С.Даваанямм:** (2016)

Би Mining Journal сэтгүүлийг уншаад зургаан жил болж байна. Сэтгүүлийн бодлого надад их таалагддаг. Монголын ард түмэнд мэдээллийн хэрэгслэлээрээ дамжуулан уул уурхайн тухай зөв ойлголтыг түгээж байна. Дийлэнх хэвлэл мэдээллийн хэрэгслэлүүд өнөөдөр уул уурхайг нэг бол айхтар магтаж, нөгөө бол голгүй муулах байдал их ажиглагддаг. Mining Journal арай өөр өнцгөөс хардаг. Уул уурхайтай хамт байж, зөвийг нь дэмжиж, өнгөтэй өөдтэй талаас нь харах сан гэсэн бодлого ажиглагдаад байдаг юм. Үүний төлөө Mining Journal сэтгүүлийн хамт олонд талархлаа илэрхийлж, амжилт хүсье.

Mongolian Mining Journal

2010-2017

# СТРАТЕГИЙН ОРД-ҮЙЛ ЯВДЛЫН ТОВЧООН

Өмнөговь аймагт өрнөж буй Оюутолгой, Тавантолгойн ордын их бүтээн байгуулалтын талаар тойм нийтлэл, сурвалжлага The Mongolian Mining Journal сэтгүүлийн хуудаснаа байнга нийтлэгддэг.

## 2010.10. № 024

### Тэнгэр говьд нүргэлэн буй бүтээн байгуулалт

(2010.10. № 024. Оюутолгойн уурхайн гүнд)



Хоолой хорсгож, нүд аргаасан нүүрсний зам ашгүй өнгөрлөө. Тавантолгойн сав газарт ирмэгцээ бид энд олборлолт явуулж байгаа гурван компанийн үйл ажиллагаатай нэг бүрчлэн танилцсан юм. Орон нутгийн өмчит "Тавантолгой" ХК, төрийн мэдлийн "Эрдэнэс МГЛ", хувийн хэвшлийн "Энержи Ресурс" компанийн үйл ажиллагааны талаар сайн, саар олон мэдээлэл байдаг ч үнэн хэрэгтээ хэн нь юу бүтээж байгааг газар дээрээс нь харахыг Ерөнхий сайд зорьжээ.





Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш таван сарын хугацаанд бүтээн байгуулалт хэрхэн өрнөж байгаатай танилцахаар Оюутолгой ордын 34 хувийг эзэмшигч Монгол Улсын Засгийн газрын тэргүүн ийнхүү зорьжээ.

## 2012.01. № 039




Ерөнхийлөгч алсыг ширтэн, хэсэгхэн зуур бодлогоширон зогсов. Явсан газар бүртээ дагалдан явсан гишүүд болон компанийн удирдлагуудыг хүнд асуултаар шавхуурдан "банга" хүртээж явсан тэрбээр хэдэн хором нэг л зөөлөн болчихов. Төрийн тэргүүн ийн зөөлөрснийг би таахдаа тэнгэр газар нийлэн үргэлжилсэн уужим тал, тэртээд цэнхэртэх Хан Жавхлант хайрхан түүнд нэгийг шивнээ болов уу гэж бодсон юм. Уул, тал үг хэлэхгүй ч хүний зүрхэнд өчлөө шивнэдэг гэдэгт би итгэдэг. Өнө удаан жил энд "амьдарсан" өвгөн хайрхан ямар ч дарга даамлаас илүүтэй үнэн үгийг Ерөнхийлөгчийн сонорт хүргээ болов уу...

## Хүйтэн өвлийн халуун айлчлал

(2012.01. № 039)

Монголын эдийн засгийг ойрын жилүүдэд өөд татах, дэлхийд дээгүүрт орох Оюутолгой, Тавантолгойн ордууд эдийн засгийн эргэлтэд аль болох хурдан орох хэрэгтэй. Өмнийн говийн энэ том ордууд улсынхаа эдийн засгийн уушги болох юм. Түүнийг хэвийн амьсгалуулж, улс орон маань тогтвортой хөгжихийн тулд байгаль орчны асуудлыг нэн тэргүүнд авч үзэж, аль болох зөв шийдэлд хүрдэг байгаасай.







## 2016.11.06 № 096

## Эхний хүдрээ гаргаж авахын тулд 60 орчим километр хонгил гаргана

Ерөнхий сайдын томилолтын үеэр "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн кэмпийн хурлын танхимд Тавантолгойн бүлэг ордод олборлолт явуулдаг төрийн өмчит, хувийн хэвшлийн, орон нутгийн нүүрс экспортлогч компаниудын захирлууд цугласан байлаа. Өрсөлдөгчид өмнө нь ингэж өөд өөдөөсөө харан асуудлаа нухацтай ярилцаж байгаагүй байх.



Оюутолгойн ил уурхайн хувьд 2011 оны наймдугаар сард хөрс хуулалтыг эхлүүлснээс хойш өдгөө дөрвөн үе шаттай олборлолт явуулж буй бөгөөд хоногт 300 орчим мянган тонн уулын цул олборлон, 100 гаруй мянган тонн хүдрийг Баяжуулах үйлдвэрт нийлүүлж байна. Ил уурхайн гүн нь 315 метрт хүрчээ.



## 2011.02. № 028

### Тавантолгойг онилсон 15 толгой

(2011.02. MMJ № 028)




Олборлогчийн сонгон шалгаруулалтад гадны гурван компани, консорциум материалаа ирүүлсэн бол стратегийн хөрөнгө оруулагчийн тендерт дотоод, гадаадын 15 толгой бүхий компани, консорциум өрсөлдөж буй тухай MMJ мэдээлсэн. 15 толгой дор нэгдсэн гадна, дотны 50 гаруй компани Тавантолгойн орд газарт хөрөнгө оруулахаар өрсөлдөж буй.

## 2011.03. № 029

### Тавантолгойн зулайд хүрсэн тэмдэглэл

(2011.03. MMJ № 029)




Тавантолгой ордын “зулай” буюу Цанхийн зүүн хэсгийн дөрөвдүгээр давхаргад явуулж буй хөрс хуулалтын ажил

...Монголчуудыг хэдэн арван жилийн турш тэжээж, хөгжилд хөтлөх аварга орд үүцээ дөнгөж нээх гэж буй эхний алхмыг нүдээр харах нь “алтан боломж” биш гэж үү. Магадгүй, “Эрдэнэс Тавантолгой”-н хөрс хуулалтыг нүдээр үзэх анхны сэтгүүлч ч байж мэднэ гэсэн олзуурхалдаа давхар хөтлөгдөх нь тэр.

## 2011.08. № 034

### “Эрдэнэс Тавантолгой” нүүрсний экспортын үнийг зарлана

(2011.08. MMJ № 034)



“Эрдэнэс МГЛ”-ын салбар компани “Эрдэнэс Тавантолгой” долдугаар сарын 26-нд 5 жилийн хугацаатай нүүрсний экспортын гэрээг Хятадын хөнгөн цагааны магнат “Chalco”-той байгуулав. Энэ хүрээнд “Эрдэнэс Тавантолгой” компани Хятадын компаниас 250 сая ам.долларыг урьдчилгаа төлбөр болгон авах бөгөөд энэ хөрөнгийг “Хүний хөгжлийн сан”-д бүрэн төвлөрүүлэх юм байна.



## 2009.06. № 006

**Б.Энэбиш:** Шийдвэр гаргах түвшинд асуудал ирчихээд байна

(2009.06. MMJ № 006)

## 2010.06. № 020

**Д.Даваасамбуу:** Тавантолгой, төмөр зам, цахилгаан станцыг салгаж болохгүй

(2010.06. MMJ № 020)

## 2012.02. № 040

**Я.Долгоржав:** Баруун Цанхийн уурхайг нээх ёслолыг тун удахгүй хийнэ

(2012.02. MMJ № 040)

## 2011.09. № 035

### “Ширхэг ч нүүрс унагалгүй сайн яваарай”

(2011.09. MMJ № 035)



**2011 оны наймдугаар сарын 04.** Төрийн өмчит “Эрдэнэс Тавантолгой” компани нүүрс экспортлох анхны цуваагаа ёслол төгөлдөр үдэх гэж буй нь энэ. Тус бүрдээ 100 тонн буюу нийтдээ 4000 тонн нүүрс дүнхийтэл ачсан хүнд даацын 40 машин алсын замд гарахаар эгнэн жагсчээ. “Өдөр тутам 4000 тонн нүүрс тасралтгүй тээвэрлэх их ажил ч эхэллээ дээ” хэмээн уурхайн ажилтнууд ярих.

## 2012.10. № 048

### Баруун Цанхийг нээсэн нь Стратегийн хөрөнгө оруулагчтай хамтрахаа больсон гэсэн үг биш

(2012.10. MMJ № 048)



... Хамтарсан Засгийн газар тарж, тоглоом мөддөө үргэлжлэхгүй гэдэг нь ойлгомжтой болох үед Б.Энэбиш Баруун Цанхийн уурхайг нээж, болохгүй бол өөрсдөө ч ашигласан яахав хэмээн төлөвлөөд байсан нь энэ сард биеллээ оллоо.

## 2015.02. № 075

### Тавантолгой төсөл хөдлөхөд бэлэн үү

(2015.02. MMJ № 075)



“Чайна Шэнхуа Энержи”, “Сумитомо”, Монголын “Энержи Ресурс” гурвын Түншлэлийн хүчээр Тавантолгой орд дэлхийн коксжих нүүрсний аварга төсөл болж өрсөлдөх ба энэ нь Консорциумтай байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээ буюу дагалдах гэрээнүүдийг Засгийн түвшинд шийдэхээс хамаарна.



## 2013.04. № 054

**О.Сайнбуян:** Манай компани стратегийн ордыг эзэмшинэ, ашиглана, хадгална

(2013.04. MMJ № 054)

## 2014.01. № 063

**Г.Тэмүүлэн:** Төрийн өмчит компанийг бизнесийн зарчмаар нь ажиллуулах хэрэгтэй

(2014.01. MMJ № 063)

## 2014.03. № 065

**Я.Батсуурь:** Угаасан нүүрс зарж эхэлбэл IPO хийхэд чухал нөлөө үзүүлнэ

(2014.03. MMJ № 065)

## 2015.03. № 076

### Тавантолгойн эмзэг цэг нь ”Чалко”-гийн өр

(2015.03. MMJ № 076)



Хөрөнгө оруулагчид “Тавантолгой” төсөл дээр зарчмын бүх асуудлаа базаж нэгтгэн, харилцан тохирол-цоонд хүрээд байтал “Чалко”-гийн өртэй холбоотой шинэ асуудал гарч ирээд хэлэлцээрийг саатууллаа.

## 2015.10.22 № 083

### Тавантолгойн төмөр замын төсөлд хамтрахаар санамж бичиг үзэглэв

(2015.10. MMJ № 083)



Японы Ерөнхий сайд Шинзо Абэгийн энэ удаагийн айлчлалын анхаарал татсан үйл явдал нь Тавантолгой-Сайншандын 455 км төмөр зам байгуулах төсөлд хамтрахаар хоёр улсын тал Санамж бичиг зурсан явдал байлаа.

## 2016.06.24 № 091

### ТТ цахилгаан станц Оюутолгойн 200 сая долларын цахилгааны импортыг дотоодод үлдээнэ

(2016.06. MMJ № 091)



Төсөлд хөрөнгө оруулах гадаадын хөрөнгө оруулагчийг сонгохоор дэлхийн нэр хүндтэй 25 компанид санал хүргүүлснээс 10 компани оролцох сонирхлоо илэрхийлжээ. Сонгон шалгаруулалт хийсний үндсэн дээр Японы “Марубени” корпорац шалгарчээ.



## 2013.09. № 059

**Аршад Саиед**: Тавантолгойг нэгтгэж ашиглах хэрэгтэй

(2013.09. MMJ № 059)

## 2016.06. № 091

**Т.Билгээ:** “Эрдэнэс Тавантолгой”-н олборлосон нүүрс 20 сая тонн болно

(2009.06. MMJ № 091)

## 2016.08. № 093

**Б.Бямбасайхан:** Сингапурын бизнесийн сайн туршлагыг Монголд нэвтрүүлэх боломж бүрдсэн

(2016.08. MMJ № 093)

## 2016.09. № 094

### “Эрдэнэс Тавантолгой”, “Энержи ресурс” хоёр хэзээ нэгдэх вэ?

(2016.09. MMJ № 094)



Харин одоо нөхцөл байдал өөр боллоо. Өмнөх жилүүд шиг Тавантолгойд хэдэн тэрбум долларын хөрөнгө оруулалт хийх стратегийн хөрөнгө оруулагч гарч ирэх боломжгүй болсон. Ийм үед өөрсдөдөө найдахаас өөр сонголт үгүй...

## 2016.11. № 096

### Нэг үнэтэй “Тавантолгойн брэнд” монголчуудад ашигтай

(2016.11. MMJ № 096)



“Эрдэнэс Тавантолгой” компани юуны түрүүнд удтал зогссон Баруун Цанхийн олборлолтыг эхлүүлэхээр боллоо. Баруун Цанхийн нүүрсээ борлуулж эхэлснээр мөнгөн урсгалтай болж, санхүүгийн хувьд тогтвортой болох боломж нээгдэнэ.

## 2017.03. № 100

### Тавантолгойн хэлэлцээр хэзээ шийдэгдэх вэ?

(2017.03. MMJ № 100)



Тавантолгойн асуудал Ерөнхийлөгчийн сонгууль өнгөртөл шийдэгдэхгүй гэдгийг төрийн албаныхан ч, төслийн оролцогч талууд ч хүлээн зөвшөөрч байна. Цаг хугацааны хувьд ч Тавантолгойн хөрөнгө оруулалтын гэрээг тохироо гэхэд наадмаас өмнө УИХ-аар хэлэлцүүлж амжихгүй биз.



## 2016.11.6 № 096

**Ж.Эрдэнэбат:**

Баруун Цанхийн нүүрсээ борлуулж эхэлснээр мөнгөн урсгалтай болж, санхүүгийн хувьд тогтвортой болох боломж нээгдэнэ.

(2016.11. MMJ № 096)

## 2016.11.6 № 096

**Г.Батцэнгэл:**

Нүүрс экспортлогч гурван компани ойлголцолд хүрсэн нь хамгийн чухал

(2016.11. MMJ № 096)

## 2009.03. MMJ № 003

### Задгай мөнгөний чимээ



2008 оны нэгдүгээр сард түрүүчийн УИХ-аас Х.Наранхүү тэргүүтэй эхний Ажлын хэсэг томилогдож, улмаар шинэ парламент бүрдсэний дараа Х.Бадамсамбуу даргатай бас нэг Ажлын хэсэг гарсан юм. Харин гурав дахь буюу Хөрөнгө оруулалтын гэрээний хэлэлцээ хийх Ажлын хэсэг ийнхүү эхний ажлынхаа үр дүнг Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулаад байна.

## 2009.08. MMJ № 010

### Хэлэлцээрийн халуун өдрүүдэд хувьцааны үнэ өндрөө хадгалсаар байна



УИХ-ын Чуулганы 2009 оны долдугаар сарын 16-ны өдрийн нэгдсэн хуралдаан 17.00 цагт эхэлж, Оюутолгойн ордыг ашиглах Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах тухай тогтоолыг анхны хэлэлцүүлгээр нь эцэслэн баталлаа.

## 2009.09. MMJ № 011

### Хувьцааны өсөлт ба талуудын ололт



Монголын Засгийн газар болоод "Айвенхоу Майнз", "Рио Тинто"-гийн төлөөллүүдийн хооронд үргэлжилсэн 3 долоо хоногийн хэлэлцээрийн явцад, цаашлаад гуравдугаар шатны хэлэлцээрийн үр дүнд эхэлсэн Ээлжит бус чуулган нээгдэх хүртэлх долдугаар сарын 27-оос наймдугаар сарын 19-ний өдрүүдэд ханшийн дээд түвшин 8.05-8.87 ам долларын хооронд тогтвортой өндөр байлаа.



## 2009.02. MMJ № 004

**Ч.Хүрэлбаатар:** "РиоТинто", "Айвенхоу Майнз"-тай хэлэлцээ хийж байгаа боловч цаана нь хөрөнгө оруулалтын банкуудтай давхар ярилцаж байна гэж ойлгодог



## 2009.03. MMJ № 005

**Д.Гарамжав:** Ханбогдын массив дээр хуйларсан дүрс гарсан байна л даа. Бараг л галактикийн хуйлрал шиг. Ийм зүйлийг бид олж харлаа



## 2009.04. MMJ № 006

**П.Очирбат:** Оюутолгойд хэрэгцээт эрчим хүчийг дотоодоосоо хангах боломжгүй

## 2009.10. MMJ № 012

### Том Албаниз шинэ өглөө нь Ерөнхийлөгчтэй уулзсан бол харин Фридланд олон нийтэд үзэгдсэнгүй




Талууд сая нэг “Оюутолгой“ төслийг хөдөлгөөнд оруулах хууль ёсны боломжийг эзэгнэх эрхтэй боллоо. Стратегийн ач холбогдлоороо түүхэнд шигшигдэн үлдэх энэ гэрээний цаашдын замнал ийнхүү тодорхой болсон 2009 оны аравдугаар сарын 6-ны өдөр, ерөөс дэлхийн уул уурхайн салбарын томоохон хүлээлтэд албан ёсны хариулт өгөв.

## 2010.06. MMJ № 020

### Г.Батсүх: Оюутолгойн ТУЗ цаг мөчтэй уралдан хичээнэ




Оюутолгой ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл анхдугаар хуралдаанаа энэ сарын 9, 10-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулжээ. Одоогоор баяжуулах үйлдвэрийн суурь цутгах, ажилчдын орон сууцны хотхон байгуулах ажил өрнөж буй аж. Оны эхэнд ажиллаж байсан 500 монгол хүний тоо өнөөдрийн байдлаар 1800 гаруй болж өссөн гэж ноён Кийт Маршалл мэдэгдсэн.

## 2010.12. MMJ № 026

### “Айвенхоу Майнз” “Рио Тинто”-гийн маргаан Улаанбаатарт шийдэгдэж, Оюутолгой “акул”-ын мэдэлд очлоо



УИХ-ын нэр бүхий гишүүд Оюутолгойн Хувь нийлүүлэгчдийн гэрээг олон нийтэд ил болгосноор Монголын талын эзэмших 34 хувь 6.8 хувь болтлоо буурна хэмээн мэдэгдсэн нь олон нийтийн анхаарлыг дахин Оюутолгой дээр татсан.
Арбитрын шүүхэд очоод байсан хоёр талын маргааны шүүх хурал хагас жилээр хойшлоод байна. Үүнээс гадна дэлхийд нөөцөөрөө тэргүүлэх Оюутолгой ордын удирдлага “Айвенхоу Майнз”-аас “Рио Тинто” руу шилжлээ.



## 2010.05. MMJ № 019

**Т.Мөнхбат:** Цахилгаан станц барья гэхээр цаг үеэсээ хоцрогдсон шийдвэрүүд төрөөс гарч байх жишээтэй



## 2010.08. MMJ № 022

**К.Маршалл:** Улс орныг бүхэлд нь өөрчилж, хөгжил хөдөлгөөнд оруулах төсөл учраас би бахархалтай ажилладаг



## 2010.12. MMJ № 026

**Том Албаниз:** Бид аль ч оронд байсан боловсролыг, залуусыг нь дэмжихийг чухал гэдгийг сайтар ойлгодог

## 2013.01. MMJ № 051

### Оюутолгойн технологийг онцлох нь



Өнгөрсөн оны Монголын уул уурхайн салбарын онцлох үйл явдлын нэг нь яах аргагүй Оюутолгойн баяжуулах үйлдвэрийн нээлт юм. Оюутолгойн баяжуулах үйлдвэр нь хоногт 100.000 тонн хүдэр, жилд 35 сая тонн хүдэр боловсруулах хүчин чадалтай. Технологийн хувьд дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдөж, батлагдсан эрсдэлгүй, орчин үеийн тоног төхөөрөмж бүхий, бүрэн автоматчилагдсан үйлдвэр.

## 2013.08. MMJ № 058

### Оюутолгойг гацаанаас гаргах эрэлхийлэл



Дөрвөн жил хамтран ажилласан бизнесийн түнштэйгээ учраа ололцох нь өнөөдөр хамгийн гол асуудал. Тиймээс ч Засгийн газар энэ удаад буулт хийж, тулгарсан асуудлаа хэвлэлээр биш, ширээний ард ярилцаж шийдье гэж байгаа бололтой.

## 2014.05. MMJ № 067

### Оюутолгойд хийсэн “аюулгүй” аялал



Оюутолгой компанийн нэн тэргүүнд аюулгүй ажиллагааны эрхэм зорилгыг Үйлдвэрлэл хариуцсан захирал асан Жак Сатогийн санаачлагаар Баяжуулах үйлдвэрийн гадна ханан дээр тунхагласан нь энэ. Дэлхийн уул уурхайн салбарт 130 гаруй жилийн түүх, туршлагатай Рио Тинто компани Монгол улсын “Оюутолгой” төсөлд дэлхийн жишигтэй аюулгүй ажиллагааг хэрхэн нэвтрүүлж буйг сурвалжлахаар Mongolian Mining Journal-ийн баг Өмнийн говьд ажиллав.



## 2012.09. MMJ № 047

**Камерон Макрей:** Эхний орлогууд оны сүүлээр орж ирэх төлөвтэй



## 2013.06. MMJ № 056

**Жек Сато:** Оюутолгой дэлхий дээр хамгийн бага ус хэрэглэдэг уурхай



## 2013.05. MMJ № 055

**Ч.Ганболд:** Шинэ үе, үйлдвэрлэлийн шат эхлэхэд дараагийн хүн энэ ажлыг үргэлжлүүлэх нь оновчтой юм

## 2014.06. MMJ № 068

### Оюутолгой ордоос олон улсын зах зээлд хүрэх баяжмал




Монгол улсын шинэ цагийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулах хүлээлт тээсэн энэ төслийн үйлдвэрлэлийн эцсийн бүтээгдэхүүн болох баяжмалыг технологийн ямар шат дамжлагатайгаар боловсруулж, гадаад зах зээлд хэрхэн нийлүүлдэг талаар сурвалжлахыг зорилоо.

## 2014.10. MMJ № 072

### Оюутолгойн гэрээ өөрчлөгдөх үү

Оюутолгойн ил уурхайн бүтээгдэхүүн. 2014.06



Монгол даяар “Оюутолгой” яах гэж байна гэж гайхсан, удахгүй шийдэгдэх нь дээ хэмээн горьдсон хүмүүс. Харамсалтай нь Оюутолгойн асуудал ойрын хугацаанд шийгдэгдэхгүй, бүр тодруулбал ирэх оны хоёрдугаар улирал хүртэл зогсонги байдалд орох, цаашид хэрхэх нь тодорхойгүй байдал үүсээд байгааг нөхцөл байдал харуулж байна. Сүүлийн 20 сар үргэлжилсэн “тоглоом” “Рио Тинто”-гийн цэвэр ялалтаар өндөрлөх нь тодорхой болоод байна.

## 2015.04. MMJ № 077

### Хөрөнгө оруулалтын гэрээг өөрчлөх “Рио Тинто” компанийн бодлого стратеги



Энэ удаа уншигч Танд танилцуулж буй презентэшн бол 2009 оны ХОГ-г үндсээр нь өөрчлөх шинэ ХОГ-ний загвар ба түүнд хийсэн дүгнэлт юм. 2014 оны аравдугаар сард Рио Тинто Монголын Засгийн газарт ОТ ордын ХОГ-г өөрчлөх төслөө явуулсан юм. Учир нь “Рио Тинто” шинэ Гэрээзний бүх нөхцөлийг хангасан тохиолдолд Далд уурхайн бүтээн байгуулалтыг эхлүүлнэ гэсэн хатуу байр суурьтай байна.



## 2015.05. MMJ № 078

**Эндрю Вүдлэй:** Оюутолгой өндөр агуулгатай хэсэгтээ олборлолт эхэлж байна



## 2016.10. MMJ № 095

**Жан Себастьян Жак:** “Оюутолгой”-д автоматжуулалтын систем нэвтрүүлнэ



## 2017.02. MMJ № 099

**Марко Пирэс:** Гүний уурхайд эхний ээлжинд 50 км хөндлөн нэвтрэлт, хонгилын ажлуудыг гүйцэтгэх ёстой

## 2015.11. MMJ № 084

### Далд уурхайг бүтээх боломжит түншүүд хуран чуулав




Mongolian Mining Journal сэтгүүлээс эрхлэн бэлтгэдэг уул уурхай, эдийн засгийн “Хөгжил” хөтөлбөр **“Эрдэнэс Тавантолгой” компанийн IPO**-гийн талаар хэлэлцүүлэг зохион байгуулсан юм.

Хэлэлцүүлэгт “Эрдэнэс Монгол” компанийн Гүйцэтгэх захирал Б.Энэбиш, Монголын Хөрөнгийн биржийн ТУЗ-ийн дарга Б.Болд, MICC Хөрөнгө оруулалтын банкны Ерөнхийлөгч Д.Ачит-Эрдэнэ нар оролцжээ.

The Mongolian Mining Journal болон түүний дэргэдэх телевизийн “Хөгжил” студийг дэмжин ажилладаг байгууллага, хувь хүмүүст Редакцийн зүгээс талархлаа илэрхийлэхийн ялдамд Та бидний тэмүүлж яваа эх орны хөгжлийн сайхан ирээдүй ойрхон, тэрхүү замыг өртөөлөн товчлоход хамтын хөдөлмөр маань өгөөжөө өгч буйг бахархан тэмдэглэе.

Mining Journal

2011-2017

## Development Studio:

# Being positive

It was in March, 2011 that the Mongolian Mining Journal decided to branch out into producing television programmes. The first of these came in April, 2011 and since then, more than 80 programmes have been produced by its team at the Development Studio, reaching thousands of viewers. The programmes are telecast during prime viewing hours by three TV channels - C1, Eagle TV and Channel 25.





The first programme was aptly titled *"Time to have a good life"* because our aim was to produce programs that would show how properly executed mining activities could have a positive influence on the country's social and economic life.

Our reporter **G.Iderkhangai** and cameraman **M.Enkh-Amgalan** braved the inclement weather in the Southern Gobi and prepared a programme that set the tone for what viewers now appreciate most in what we offer: a clear assertion of how expansion in mining adds speed and energy to the nation's development. Over time, Development Studio programmes have improved in quality and widened their range. Several of them have covered major investment forums held abroad and creative graphic designs have been most effectively used to explain the new technology used in mineral processing plants.

The Mongolian Mining Journal and Development Studio are proud to have a gifted team of journalists and technicians. **S.Bold-Erdene** covers developments in the financial market and **B.Tugsbilegt** unravels the complexity of movements in raw material prices and shifting market trends. **G.Iderkhangai** analyses problems of infrastructure development and of the legal environment in the mining sector, while **O.Khostsetseg** specialises in programmes on the environment and use of new technology. **E.Odjargal** focuses on safety aspects in mining operations and **S.Bold-Erdene** is in charge of presenting reports from investors' conferences and forums taking place outside Mongolia.




The staff of Mongolian Mining Journal and Hugjil Studio would like to thank all advertisers, readers and well-wishers for their support over the years. We are proud to have you with us on this path to a prosperous future for our nation.

It is not always plain reportage. Our programmes have included analysis and debates on the legal and investment environment in the mining sector. Apart from full-length TV productions, we also make short videos and documentaries based on our rich database of mining sector statistics and audio and video archives covering major mining events in Mongolia in the past years.

It prepares programmes of many different types, and those demonstrating the progress of mining technology have been made with a professional competence not seen before in Mongolia. You can view Hugjil Studio's programmes by going to www.mongolianminingjournal.com.

It also makes all sorts of plugs and videos as requested by mining companies and suppliers. These can be seen on the iPad version of the magazine.

The documentary film it made to mark the 10th year of Discover Mongolia was so well received that the studio now has ambitious plans to use its vast archives to make many such films in the coming days.

**Hugjil Studio can be contacted at 77222400, 99997400**

2010-2014

Mining Journal

# AWARDS

Монголын уул уурхайн салбарт хариуцлагатай үйл ажиллагааг төлөвшүүлэх, өндөр эрсдэл үүрэн хөдөлмөрлөж буй салбарын хамт олны нөр их ажлын үр дүнг олон нийтэд зөв таниулах зорилготой, хараат бус шалгаруулалт туйлаас чухал болсон үед Mining Journal Awards арга хэмжээ анх 2010 онд зохион байгуулагджээ.

Эдүгээ Mining Journal Awards шалгаруулалт нь Хараат бус, номинацид нэр дэвшигчдээс ямар нэг төлбөр мөнгө авахыг хатуу хориглодог, Мэргэжлийн шүүгчид дүгнэдэг гэсэн үзүүлэл-тээрээ салбартаа төдийгүй, Монголын нийгэмд танигдсан нэр хүндтэй арга хэмжээ болжээ.



Шүүгчдийн Зөвлөл цуврал хуралдаан хийж, оноо өгөх зарчмаар шалгаруулалтын дүнг гаргадаг.

Уул уурхайн салбарын шалгаруулалт нь компаниудын төлсөн мөнгөний хэмжээгээр хийгддэг, эсвэл төрийн аль нэг байгууллагын захиргаадалтаар шийддэг буруу хандлагыг өөрчлөх зорилгоор зохион байгуулсан анхны арга хэмжээ юм.

Уул уурхай, байгаль орчны салбарын эрдэмтэн судлаачид болон иргэний нийгмийн төлөөллөөс сонгогдсон Шүүгчдийн зөвлөлийн бүрэлдэхүүн шалгаруулалтыг мэргэжлийн түвшинд шүүн явуулдаг. Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн ерөнхийлөгч **Н.Алгаа,** ШУТИС-ийн харьяа Уул уурхайн хүрээлэнгийн захирал, доктор, профессор **Б.Пүрэвтогтох,** Маркшейдерийн холбооны тэргүүн, ШУТИС-ийн зөвлөх, аж үйлдвэрийн гавьяат ажилтан, доктор, профессор **Д.Дондов,** БОЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газрын дарга **Д.Энхбат,** МХЕГ-ын Байгаль орчин, Аялал жуулчлал, Геологи, Уул уурхайн хяналтын газрын дарга **Н.Батбаяр** нар Шүүгчдийн бүрэлдэхүүнд анх багтаж байсан бол хоёр дахь удаагийн арга хэмжээний Шүүгчдийн Зөвлөл хүрээгээ тэлж, мэргэжлийн нэр хүндтэй хүмүүс нэмэгдэж орсон юм.

“Mining Journal Awards”-ын шалгуур үзүүлэлт бүхий урилгыг Монголд үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн бүх компанид илгээдэг бөгөөд номинацид өрсөлдөхөөр компаниуд шалгуур үзүүлэлтийн дагуу материалаа нягт нямбай бэлтгэн, сэтгүүлийн редакцийн хаягаар ирүүлдэг. Тухайн жилд хийсэн ажлынхаа тайланг уул уурхайн том, жижиг олон компани ирүүлдэг. Шүүгчдийн зөвлөл харьцуулсан шалгуур үзүүлэлтийн дагуу тэдгээрт оноо өгөн, нэгтгэх дараалаар дүгнэдэг. “Энержи ресурс”, “Оюутолгой”, МАК зэрэг өнөө цагийн уул уурхайн хөгжлийг тодорхойлж буй компаниудаас гадна “Эрдэнэт үйлдвэр”, “Монполимет”, “Багануур” зэрэг олон арван жил Монголын уул уурхайн хөгжлийн нүүр царай болж яваа томоохон компаниуд мөн нэрээ дэвшүүлдэг уламжлалтай.

## Mining Journal Awards - **2011**










## Mining Journal Awards - **2012**















Mining Journal Awards-ийн шалгаруулалтад жил тутам компаниудаас ирүүлдэг тайлан материал нь эдүгээ геологи, уул уурхайн салбарын хөгжил, өсөлт бууралтын хандлагыг илэрхийлэхүйц судалгааны далайцтай Сан болон бүрдээд байна.

Mining Journal

# AWARDS

2010-2014

# Mining Journal Awards:

## Recognition without fear or favour

The Mining Journal Awards were instituted in 2010 to give recognition to and honor the activities and results of hard work in this sector. In only four years, the fairness and independence shown in the selections have marked it out among similar events where awards are won because of successful lobbying, or for financial and other considerations. The Mining Journal Awards are valued, by players in the mining sector as also by people in general, because they are chosen by a panel of independent jurors with professional expertise and because there is a total ban on receiving any payment in any form from contestants.

An invitation to submit their nomination is sent to every mining company in Mongolia, big and small. They are requested to forward to the magazine's office their claim along with supportive evidence prepared according to a specified format. Evaluations by individual jurors are then compared and tallied to reach the final decisions.

Among those vying for the honours have been companies that have come to define mining in Mongolia in recent days such as Energy Resources, OyuTolgoi and MAK, as also those who have been part of tradition like Erdenet Mining Corporation, Monpolymet and Baganuur. Among those who have successfully staked their claim to an award for their use of the most up-to-date technology have been Erdmin, TavanTalst, BulganGangat, Tanan-Impex, Shijir Alt and Major Drilling.



## Mining Journal Awards - 2010




The evaluation system adopted by the committee gives equal chance to smaller companies, thus making the event truly representative.

The awards are given for achievement in the following fields:

**Mining Operation**
**Eco-friendly Mining**
**Use of Technology**
**Best exploration work**

The winner of the award for the Best Supporter is chosen on the basis of public opinion received during a month-long poll.

More information on the criteria and conditions of the awards can be found at www.mongolianminingjournal.com. You are welcome to see reports on the two Mining Journal Awards at the Event menu on our website www.mongolianminingjournal.com.

## Mining Journal Awards - 2011




info@mongolianminingjournal.com
tugs@mongolianminingjournal.com




## Mining Journal Awards - 2012




The annual submissions by companies competing for the prestigious Mining Journal Awards contain enormously valuable material on development of the geology and mining sectors. We store these in our archives, which thus become a rich treasury for present and future research on how individual companies grow, and on the bigger field of the development path of the mining sector. The decision to add a new criterion for the Awards this year, to be called “consistent work indicators”, will bring in more such information.

Similarly, companies vying for the “best in eco mining” award submit detailed information on their work in land rehabilitation, water recycling etc. A comparative study of these in the archives will indicate how this new trend in mining caught up in the country.

## Mining Journal Awards - 2013






## Mining Journal Awards - 2014





Incidentally, the winner in this category is chosen by a team of professionals from the Ministry of Environment and Green Development.







“Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” нь сэтгүүлчдийн санаачлагаар байгуулагдсан.

Mongolian Mining Journal

2010-2017

“Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” ТББ

# JOURNALISM FOR DEVELOPMENT

Уул уурхай, эдийн засгийн чиглэлээр дагнан бичиж буй сэтгүүлчдийг өндөр түвшинд мэргэшүүлэх, салбарын тухай хамгийн сүүлийн үеийн мэдээллээр хангах, уул уурхайн үйл ажиллагааг газар дээрээс нь сурвалжлах боломж олгох, олон улсын санхүүгийн байгууллагууд, түүнчлэн мэдээллийн нэр хүндтэй редакциудад танилцах аялал зохион байгуулах зэрэг олон талт үйл ажиллагаа явуулдаг.

www.journalism.mn




*Бидэнтэй хамтран ажиллах болон бусад санал хүсэлтээ info@journalism.mn хаягаар ирүүлнэ үү.*

Хөгжлийн төлөө сэтгүүл зүй ТББ-ын нээлтийн хэвлэлийн хурал. 2010.05.25

"Хөгжлийн төлөө сэтгүүл зүй" төрийн бус байгууллага нь сэтгүүлчдийг мэргэшүүлэх сургалтуудаа үнэ төлбөргүй явуулдаг. Сургалтад үндэсний хэмжээний томоохон мэдээллийн байгууллагын сэтгүүлчид, түүнчлэн орон нутгийн телевиз, сонин, радиогийн удирдах ажилтнууд, сурвалжлагчид өргөнөөр хамрагддаг.




Хууль зүй, дотоод хэргийн яамтай хамтран хийсэн 81 хуулийн хэрэгжилтийн талаарх хэлэлцүүлэг.
2010.5 сар



Хөрөнгийн зах зээлтэй танилцах сургалт. 2010.5 сар

Өнгөрсөн хугацаанд арав гаруй сургалтыг дотоодод; мөн хилийн чанадад танилцах аяллыг зохион байгуулжээ. Хонконгийн Хөрөнгийн биржийн тухай анхан шатны ойлголтыг Монголын сэтгүүлчдэд, улмаар уншигч, үзэгчдэд ойлгуулах аяллыг 2010 онд хийсэн бөгөөд хөрөнгийн захын үйл ажиллагааны тухай шат дараалсан мэдлэг мэдээллийг хүргэх сургалтыг тасралтгүй явуулж ирэв.





Эдийн засгийн сэтгүүлчдэд зориулсан сургалт. 2010.5 сар





Телевизийн тоон системийн шилжилтийн талаарх бодлого, үйл явц. 2010.4 сар

Тухайлбал, "ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ОЙЛГОЛТ" сэдвээр МУИС-ийн ЭЗС-ийн Санхүүгийн тэнхмийн багш Д.Одбилэг, MICC-ийн Ерөнхийлөгч Д. Ачит-Эрдэнэ, "ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА" сэдвээр Хөрөнгийн биржийн мэргэжилтэн Э.Одбаяр, "Эдийн засгийн ухаан, Бизнесийн мөчлөг ба санхүү, Эдийн засгийн үзүүлэлтүүд, Үзүүлэлтүүдийн уялдаа холбоо, төрийн бодлого" сэдвээр Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Захирал, доктор Б.Түвшинтөгсийн сургалт зэргийг амжилттай зохион байгуулжээ. Дээрх сургалтууд нь 2010 он буюу хөрөнгийн зах зээлийн тухай ойлголт Монголын нийгэмд төлөвшиж дөнгөж эхэлж байсан үед сэтгүүлчдэд анхан шатны мэдлэг өгснөөрөө үнэ цэнтэй, өндөр өгөөжтэй ажлууд байв.

## Монголын сэтгүүлчдийн эвлэлийн Ерөнхийлөгч Б.Галаарид: (2013)

Mongolian Mining Journal-ын хамт олонд уран бүтээлийн өндөр амжилт хүсье. Аливаа сэтгүүл өөрийн гэсэн өнгө төрх, орон зайтайгаар янз бүрийн цаг хугацаанд амьдардаг. Миний хувьд Mongolian Mining Journal-ыг Монголын шинэ сэтгүүл зүйд шинэ өнгө төрх авчирсан, цоо шинэ, мэргэжлийн стандартыг бий болгосон сэтгүүл гэж хардаг. Нэрнээс нь болоод мөнгөтэй холбох зэргээр манайхан янз бүрээр ойлгодог юм шиг байна лээ. Би тэгж хардаггүй. Яагаад гэхээр сэтгүүл зүй өөрөө бизнес. Энэ бизнесийг яг орчин үеийн шаардлагынх нь дагуу хийх ёстой. Түүнээс биш мөнгө өгвөл магтана гэдэг тэр үе өнгөрсөн байна. Өнөөдөр бизнес утгаар нь хэвлэл мэдээллийн хэрэгслэлийг байгуулан, жинхэнэ мэргэжлийн түвшний сэтгүүл гаргаж, хамгийн гол нь асуудлыг мэргэжлийн түвшинд гаргаж тавьдаг цөөхөн сэтгүүлийн нэг нь Mongolian Mining Journal.

Манай шинэ сэтгүүл зүйд, ялангуяа сэтгүүлийн төрөлд ирээдүйн чиг хандлага ийм л байна шүү гэдэг тэр стандартыг тодорхойлсон сэтгүүл бол Mongolian Mining Journal гэж хэлмээр байна. Монголын сэтгүүл зүй сүүлийн жилүүдэд технологийн хувьд, стандартын хувьд урагшаа том алхаж байгааг хэлэх хэрэгтэй. Жишээ нь, телевизийн салбарт маш олон дэвшил гарч байна. Сэтгүүлийн салбарт бас том дэвшлүүд бий болж байна. Гадаадын нэр хүндтэй брэнд болсон сэтгүүлүүд орж ирж байна. Үүнтэй зэрэгцээд Монголын сэтгүүлчид өөрсдөө яг тэр түвшний, салбарын мэргэшсэн сэтгүүлийг гаргаж байгаад МСЭ-ийн Ерөнхийлөгчийн хувьд баяртай байдаг. Танай сэтгүүл асуудлыг тавьж чаддаг, мэргэжлийн түвшинд хөндөж чаддаг, мөн асуудлыг олж харж чаддаг.




## Хэвлэлийн хүрээлэнгийн Гүйцэтгэх захирал М.Мөнхмандах: (2013)

Mongolian Mining Journal бол Монголын эдийн засгийн маш чухал салбарын тулгамдаж байгаа асуудлуудад төвлөрч, тодорхой мэргэжилтнүүдийн мэдээлэл, байр суурь, тоймыг өгч байдаг маш чухал мэдээллийн эх сурвалж. Ялангуяа уул уурхайн салбарт бодлого шийдвэр гаргаж байгаа хүмүүс, хууль тогтоогчид, эдийн засагчид, хөрөнгө оруулагч, хувийн хэвшлийнхэнд мэдээллийн маш чухал эх сурвалж юм болов уу гэж боддог.

Өнөөдөр Монголын зах зээл дээр сэтгүүлүүд хөгжин цэцэглэж байгаа. Хэвлэл мэдээллийн бусад байгууллагууд зах зээл нь хумигдаад тоо нь багасч буй энэ үед сэтгүүлүүдийн тоо ч нэмэгдэж, борлуулалт нь ч өсч байна. Үүн дотор өөрийн гэсэн баттай байр суурь эзэлсэн, байнгын хэрэглэгч уншигчтай сэтгүүл бол Mongolian Mining Journal. Өнөөдөр хэвлэл мэдээллийн хэрэгслэлийн хэрэглэгчид юуг хүсч байна гэхээр найдвартай мэдээлэл, тайлбар хүсч байна. Зүгээр нэг болоод өнгөрсөн үйл явдлыг боллоо гэж мэдээлэхээс илүү уг мэдээлэл ямар ач холбогдолтой, юуг өөрчлөх гэж байгаа, урьд нь юу болж байсан, цаашид юу болох вэ гэсэн тайлбарыг мэргэжлийн өндөр түвшинд хүргэдэг сэтгүүл бол Mongolian Mining Journal гэж хардаг.





## “Орон нутгийн сэтгүүлчдийн сүлжээ-2010”

Уул уурхайн үйл ажиллагаа эрчимтэй явагдаж буй Өмнөговь аймгийн хэвлэл мэдээллийн бүх байгууллагын сэтгүүлчид оролцсон сургалтаа “Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” нь 2010 онд зохион байгуулсан бөгөөд орон нутгийн сэтгүүлчдэд эдийн засаг, уул уурхайн салбарын тухай ойлголт өгсөн анхны сургалтын ажил болсон гэдгээрээ Монголын хэвлэлийн түүхэнд үлдэх үйл явдал юм.





MMJ-ийн сэтгүүлчид заах аргын онолын ямар ч мэдлэггүй ч өөрсдийн сурвалжлан бичих ажилд тохиолддог зүйлс, туулсан туршлагын хүрээнд сургалтын хөтөлбөр боловсруулан эхний жилийн сургалтыг явуулсан билээ.

Уул уурхай, эдийн засгийн чиглэлээр нийтлэл бичиж, нэвтрүүлэг хийдэг бидэнд сургах гэхээсээ илүү сэтгүүлч андуудтайгаа хуваалцах туршлага байсан юм. Орон нутгийн сэтгүүлчид үзэг нэгтнүүдийнхээ хөдөлмөрийг үнэлж, ийм практик сургалтын үнэ цэн зайлшгүй байгааг хэлж, цаашид үргэлжлүүлэх том урам өгсөн.













Уул уурхай, эдийн засгийн мэдээллийг мэргэжлийн түвшинд бэлтгэдэг сэтгүүлчдийг улам олон болгох зорилгоо тэлсээр 2015 онд “Орон нутгийн сэтгүүлчдийн мэдээллийн сүлжээ” байгуулав. Орон нутгийн иргэдэд уул уурхайн мөн чанарыг ойлгуулах, бодит мэдээллээр хангахын тулд орон нутгийн редакци, сэтгүүлчдийг мэргэжлийн арга зүйгээр дэмжих гэсэн бидний тэмүүллийг Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ)-ийн ЭТИС хөтөлбөр дэмжсэнээр 2015 оны тавдугаар сард төслөө эхлүүлсэн юм.



Mining Mongolian Journal

германы хамтын ажиллагаа DEUTSCHE ZUSAMMENARBEIT

Хэрэгжүүлэгч: giz Deutsche Gesellschaft für Internationale Zusammenarbeit (GIZ) GmbH

# “Орон нутгийн сэтгүүлчдийн сүлжээ” төслийн ХОЙД БҮСИЙН СУРГАЛТ -2015

**2015.05.26-27. Сэлэнгэ аймаг. Сүхбаатар хот**

The Mongolian Mining Journal сэтгүүлийн дэргэдэх “Хөгжлийн төлөө сэтгүүлзүй” ТББ-ын баг тавдугаар сарын 26-27-нд Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хотод “Орон нутгийн сэтгүүлчдийн сүлжээ” төслийн Хойд бүсийн сэтгүүлчдийн сургалтыг амжилттай зохион байгууллаа.



# “Орон нутгийн  сэтгүүлчдийн сүлжээ” төслийн БАРУУН БҮСИЙН СУРГАЛТ 2015

**2015.06.25.  Баянхонгор аймаг.**







Сэтгүүлчдийг мэргэжлийн арга зүйгээр дэмжсэнээр, олж авсан мэдлэг, ойлголтынх нь цаана орон нутгийн иргэд бодит мэдээлэл хүлээж авах ач тусыг “Хөгжлийн төлөө сэтгүүлзүй”, төслийг дэмжигч байгууллагууд аль аль нь хүлээж байгаа.

# “Орон нутгийн сэтгүүлчдийн сүлжээ” төслийн НЭГДСЭН УУЛЗАЛТ 2015

**2015.11.10.  Улаанбаатар хот. Blue sky Tower**

Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан “Орон нутгийн сэтгүүлчдийн сүлжээ” төслийн Нэгдсэн уулзалтад Хойд, Өмнөд, Баруун бүсийн сэтгүүлчид идэвхтэй оролцсон юм.



Mongolian Mining Journal-ийн дэргэдэх “Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” ТББ таван жилийн турш хэрэгжүүлж байгаа сэтгүүлчдийг чадавхижуулах сургалтынхаа хүрээг тэлж, “Орон нутгийн сэтгүүлчдийн сүлжээ” төслөөр өргөтгөснийхөө Нэгдсэн уулзалтыг зохион байгуулж буй нь энэ.

Сургалтад оролцсон нийт сэтгүүлчдийн дунд уралдаан зарлах, нийслэл хотноо нэгдсэн уулзалт хийх, гадаадын уул уурхайн сургуулиудын мэргэжлийн профессоруудыг урьж хичээл заалгах, танилцах аялал зохион байгуулах зэргээр уг төслөө далайцтай болгон өргөжүүлэх шаардлага гарсан юм.

# “Орон нутгийн сэтгүүлчдийн сүлжээ” төслийн НЭГДСЭН СУРГАЛТ -2016

**2016.04.2. Улаанбаатар хот**



Амжилттай хэрэгжсэн төслийг үргэлжлүүлэх, орон нутгийн сэтгүүлчдийн эргэх холбоо, ур чадварыг дахин шат ахиулах зорилгоор 2016 оны “Орон нутгийн сэтгүүлчдийн сүлжээ” төсөл ажлаа эрчтэйгээр эхэллээ. Энэ удаад ЭТИС хөтөлбөр Германы туршлагатай, нэр хүндтэй сэтгүүлчийг урьсан юм. 2016 оны сургалтад өмнөх сургалтад хамрагдсан орон нутгийн хэвлэлийнхнээс 35 сэтгүүлч шигшигдэн оролцов.

2015 оноос эхэлсэн “Орон нутгийн сэтгүүлчдийн сүлжээ” төслийн хүрээнд орон нутгийн сэтгүүлчдийг уул уурхайн сэдвээр мэргэшүүлэн, чадавхжуулах сургалтыг бүсчлэн зохион байгуулсан билээ. Сургалтын дараа орон нутгийн сэтгүүлчдээс уул уурхайн үйлдвэртэй биечлэн танилцах хүсэлт цөөнгүй ирсэн юм. Тэрхүү санал төслийн 2 дахь жилийн сургалтын хөтөлбөрт тусгалаа олж, Бороогийн алтны уурхайтай танилцах аяллаар 2016 оны анхны сургалтаа нээсэн.









# “Орон нутгийн сэтгүүлчдийн сүлжээ” төслийн НЭГДСЭН СУРГАЛТ -2016

**2016.08.14-15. Өвөрхангай. Хархорин сум**



Төслөөс хэрэгжүүлж байгаа сургалт бүр өөрийн онцлогтой, шинэ санаа сэдвээр баяжигдсан, өмнөх сургалтуудынхаа үр дүнд суурилсан байдгаараа орон нутгийн сэтгүүлчдийн анхаарлыг татдаг. Энэ удаагийн сургалт дан сэтгүүл зүйн сэдвүүдээр дагнасан нь онцлог байв.



# “Орон нутгийн сэтгүүлчдийн сүлжээ” төслийн НЭГДСЭН СУРГАЛТ -2016

**2016.11.14-15. Улаанбаатар хот**





Өнгөрсөн хугацаанд төслийн хүрээнд өөр өөрийн онцлог, үе шаттай зургаан удаагийн цуврал сургалтыг 15 аймгийн 70 орчим сэтгүүлчийг хамруулан зохион байгуулжээ. Эдгээр сургалтад идэвхтэй оролцсон 35 сэтгүүлч төгсгөлийн сургалт семинарт хамрагдсан юм.

The Mongolian Mining Journal сэтгүүл, түүний дэргэдэх “Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” ТББ-аас ЭТИС хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр хоёр дахь жилдээ амжилттай зохион байгуулсан энэхүү төслийн хаалтын нэгдсэн семинар арваннэгдүгээр сарын 14-15-нд Улаанбаатар хотноо боллоо. Өмнөх өдрүүдэд нь хот, хөдөөгүй цасаар шуурч, цаг агаар огцом хүйтэрсэн ч орон нутгийн сэтгүүлчид хүндрэл бэрхшээлийг үл ажран зорьсон газартаа, товлосон цагтаа цугларсан юм.

# “Орон нутгийн сэтгүүлчдийн сүлжээ” төслийн НЭГДСЭН СУРГАЛТ -2017

**Өмнөговь аймаг**

| | |
|---|---|
| Ханбогд | 2017.06-28-29 |
| Цогтцэций | 2017.06.30 |
| Даланзадгад | 2017.07.1-2 |




**Долдугаар сарын 28-ны өглөө.** Монгол орны 21 аймгаас ирсэн сэтгүүлчид нийслэл хотын хөл хөдөлгөөн эхлэхээс урьтан өмнийн говийн уул уурхайн үйл ажиллагаатай танилцахаар аян замдаа гарлаа. “Орон нутгийн сэтгүүлчдийн сүлжээ” төсөл энэ жил хүрээгээ тэлж, 21 аймгийн сэтгүүлчдийг сургалтад хамруулж байгаа юм.



“Орон нутгийн сэтгүүлчдийн сүлжээ” төслийн гуравдугаар шатны ажилд ЭТИС хөтөлбөр дэмжлэг үзүүлснээр 2017 оны төслийн үйл ажиллагаагаа өмнийн говийн уул уурхайн үйлдвэрлэлтэй танилцах аяллаар эхэллээ.



2017 оны сургалтад 21 аймгийн 39 сэтгүүлч хамрагдсанаар Монгол улсын өнцөг булан бүрт хүрсэн сүлжээ бий болж байна. Сургалтын үе шат бүхэнд орон нутгийн сэтгүүлчид чадавхжиж, уул уурхайн талаарх мэдлэг, ойлголт гүнзгийрч буй нь нийтлэл, нэвтрүүлгээс нь тодорхой харагддаг билээ. Үүний цаана орон нутгийн ард иргэд эрдэс баялгийн салбарын олон талт сэдвээр бодитой мэдээлэл олж авах ач тус оршиж байгаа юм.







2017 онд орон нутгийн сэтгүүлчдийн хүсэлтээр сургалтын агуулгыг тэлж, уул уурхайн үйлдвэрлэл хамгийн эрчимтэй өрнөж буй өмнөд бүс нутгийг зорьсон билээ.

Сэтгүүлчид Ухаахудаг уурхайн бүтээн байгуулалт, тэр дундаа жилдээ 15 сая тонн нүүрс боловсруулах хүчин чадалтай Нүүрс баяжуулах үйлдвэр, дөрвөн аймгийг цахилгаанаар хангахуйц эрчим хүч үйлдвэрлэх, байгальд ээлтэй Цахилгаан станц, 600 хүүхдийн “Мөрөөдөл” сургууль, 150 хүүхдийн цэцэрлэг, 100 хүүхдийн дотуур байр, Цэций хороолoлтой танилцлаа.







Орон нутгийн сэтгүүлчдийн танилцах аялал Тавантолгойн Цанхийн Баруун, Зүүн уурхайд олборлолт явуулж буй төрийн өмчит Эрдэнэс Тавантолгойн уурхайтай танилцсанаар үргэлжлэв.









21 аймгийн сэтгүүлчдийг өмнийн говийн уул уурхайн үйлдвэрлэлтэй танилцуулах аяллыг дэмжиж, уурхай, үйлдвэрлэлийнхээ үйл ажиллагаатай танилцах боломжийг олгосон “Оюутолгой” ХХК, “Энержи ресурс” ХХК, “Эрдэнэс Тавантолгой” ХК болон Өмнөговь аймгийн нутгийн захиргааны байгууллага, Ханбогд сумын ИТХ, Засаг даргын Тамгын газарт сургалтыг зохион байгуулсан Хөгжлийн төлөө сэтгүүл зүй, The Mongolian Mining Journal сэтгүүлийн редакциас гүн талархал илэрхийлье.



# Journalism for Development: Focusing on balance and accuracy

Journalism for Development is a non-Governmental organization founded at the initiatives of journalists, mainly to provide training to journalists covering developments in mining and the economy on how to collect and use up-to-date information, and to write on-site reports. They have been taken to international financial organisations and news studios to get an idea of how these work.

It has so far arranged more than ten seminars and trainings within the country and outside. A 2010 study trip to the Hong Kong Stock Exchange was very effective in providing an understanding of stock exchange work to not just Mongolian journalists, but also to readers of the print media and TV viewers. That year, when





Mongolians were waking up to the concept of stock markets, the following seminars were successfully organized by this NGO to enrich their understanding of how these work:

- “Concept of Securities Market”, with D.Odbileg, Financial Department professor at the School of Finance and Economics of the National University of Mongolia, and D.Achit-Erdene, President of MICC

- “Stock Exchange”, with E.Odbayar, a stock exchange expert

- “Study of Economics, Business Cycle and Finance, Economic Indicators, Interrelation of the Indicators and State Policy”, with Dr B.Tuvshintugs,Ph.D and Director of the Economic Studies and Science Academy.



All trainings Journalism for Development organizes are free and are open to those working for both national and local media organisations, including television channels, newspapers and radio stations. Attendance is widespread and has been marked by active participation.

One particular seminar held in Umnugovi aimag, the hub of mining activity in the country, deserves special mention. It brought together journalists from all kinds of local media organisations and was devoted to explaining to them a basic understanding of the relation between the national economy and the mining sector.

The TV programme based on the trip to the Hong Kong Stock Exchange was followed by another on the work of Bloomberg in Singapore. Both were very popular when they were aired through TV channels in Mongolia.

Seminars held by Journalism for Development focus on various facets of mining sector activities, such as use of proper technology, metal classification, the economics of mining, tax issues, and international practices and trends.

More information can be found at www.journalism.mn and info@journailsm.mn and by calling 976-77222400 or 976-77222300.

## Participants remember one Journalism for Development seminar

**S.Nomintsetseg, Director of “AltanGovi TV”** in Umnugovi aimag: I think the seminar was very helpful in improving the professional skills of our local journalists. I hope your activities expand well. We will also do our best to develop journalism in our area. I wish nothing but the best for our future cooperation.



**U.Amartuvshin, journalist at AltanGovi TV:** For a while I worked in a different field but I missed journalism which is what I’m passionate about and I came back to my television work. The seminar was soon after this and gave me the opportunity to widen my understanding and get new insights into the special nature and demands of economic journalism. I now approach my work with fresh energy and goals and I thank you very much for this.



**J.Sainjargal, journalist at Mongol Govi newspaper, Umnugovi aimag:** Thank you very much for coming to Umnugovi to give us this opportunity. I had attended several training courses earlier but this one was much more informative and productive and I am so glad I was here. We now realise how very crucial it is for all local journalists to cooperate, to be united and to speak in one voice to be more effective.



**Ts.Gandelger, journalist at AltanGovi TV: I** really liked the course. A local channel like ours can usually spare one person, or at most a team of two, to work on one programme, but we learnt that the practice in Ulaanbaatar is to put 5-6 people to work together as a team on one programme. We believe local journalism is ready to develop. We are proud that we are able to deliver news to local residents, who are more interested in their own TV and newspapers rather than in what is shown on Ulaanbaatar TV channels. We should improve our skills to meet their demands better and the two-day seminar has given me the confidence and the skill to ask the right questions when interviewing someone.



**B.Byambasaikhan, journalist at 21st Channel TV:** For some time journalists of Umnugovi aimag were feeling the need to work together, and this event showed us how to forge an efficient system of cooperation. I am sure what you started here at the Gobi will become more and more successful with time.

## Bloomberg, Singapore



“Хөгжлийн төлөө сэтгүүл зүй” нь Хонконгийн Хөрөнгийн биржид хийсэн танилцах аяллынхаа тухай, Блүүмбергийн Сингапур дахь салбараас хийсэн сурвалжлагуудаараа сэтгүүлчдэд зориулсан нэвтрүүлэг тус тус бэлтгэн телевизийн сувгуудаар цацсан билээ. (2014.4) www.journalism.mn

## Bloomberg Television, HasLinda Amin



Хаслинда хэдийгээр завгүй, хэдхэн минутын дараа эфирт гарах байсан ч бидэнтэй зургаа татуулж, хэдэн үг сольсон билээ. Блүүмбергийн нэртэй сэтгүүлч-хөтлөгч түүнтэй Mongolian Mining Journal-ийн сэтгүүлч сонирхолтой ярилцлага хийн, Монголын үзэгчдэд хүргэсэн билээ. (2014.4)

## 2015.03.27

Улаанбаатар



Канадын Бритиш Коламбийн Их сургуулийн Норман Кийвилийн нэрэмжит Уул уурхайн институттэй нягт хамтран ажиллаж, 2015 оноос төсөл хэрэгжүүлж байна. Тус Институтийн дэлхийд нэр хүндтэй профессорууд MMJ-ийн Редакцийн байнгын зочин болдог.





## 2016.04

Улаанбаатар

“Орон нутгийн мэдээллийн сүлжээ” төслийн 2016 оны эхний сургалтыг удирдсан ХБНГУ-ын Дойчэ Вэллэ академи болон Брэмений хэрэглээний Шинжлэх ухааны их сургуулийн сургагч багш сэтгүүлч, доктор Дирк Асэндорпф Mongolian Mining Journal сэтгүүлийн редакцид зочиллоо.





## 2017.04.17
Гүрж. Тбилиси хот







Байгалийн баялгийн нөөцтэй, улсынх нь төсөв уул уурхайн орлогоос хамааралтай, улс дамнасан томоохон корпорациуд олборлох үйл ажиллагаа явуулдаг, эдийн засгийн хувьд дундаж хөгжилтэй орнуудын эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хангахад сэтгүүлчдийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх зорилготой сургалт Тбилиси хотноо зохиогдсон юм. Ийм төрлийн сургалтыг улс орнуудаар бүсчлэн зохиох бөгөөд энэ удаад Төв болоод Дунд Азийн бүс нутгийн Монгол, Киргиз, Азербайжан, Узбекистан, Украйн, Гүрж улсын сэтгүүлчдийг хамруулсан ба Монголоос The Mongolian Mining Journal оролцоод ирлээ.

## 2017.04.22
Австрали. Брисбэнд хот



ММJ-ийн сэтгүүлчид Австралийн Квийнсландын их сургуулийн эдийн засаг, бизнес, уул уурхайн сэтгүүл зүйн онол, практикийн мэргэжлийн сургалтад хамрагдан төгсөв.





Эдийн засаг, уул уурхайн сэтгүүлчдийг чадавхжуулах, мэргэшүүлэх зорилготой Германы хамтын ажиллагааны нийгэмлэгийн Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачилга төслийн хүрээнд Монголын арав гаруй сэтгүүлч Австралийн уул уурхайн хөгжил, дэвшилтэй танилцахаар Квийнсланд мужийн төв Брисбэнд ирсэн юм.






“Эдийн засгийн сэдэвтэй сэтгүүл зүйн бүтээлд нэр нь хамгийн олон удаа дурдагдсан эдийн засагч, шинжээч, нийгмийн зүтгэлтнийг тодруулах судалгаа”-г Монголын Хэвлэлийн хүрээлэнтэй хамтран 2010 оны эхний хагасын хэвлэлүүдэд түшиглэн ММЈ хийсэн бөгөөд олон нийтийн зүгээс тавьж буй “Яагаад, яаж” хэмээх асуултуудын хариуг өгөхийг чармайсан нэр бүхий Эрхмүүд энд тодорчээ. Хөгжлийн зөв гарцын тухай хамгийн ихээр маргаж буй цаг үед олон нийт эдгээр хүмүүсийн байр суурийг сонсох, харьцуулан дүгнэхийг оролдсон байх аж.

ММЈ судалгааны ажлаа цаашид тогтмолжуулан, уул уурхайн чиглэлээр түлхүү анализ хийнэ.

Эдийн засгийн сэдвээр 2010 оны эхний хагаст хамгийн олон удаа байр суурь илэрхийлсэн; бодлогод нөлөөлж чадсан; олон нийт үгийг нь сонсохыг хүссэн номинациудаар шалгарсан Найман Эрхэмд ММЈ шагналыг нь гардууллаа.

2010 оны долдугаар сар

Судалгааны дүнгээс үзэхэд **24** нийтлэлчийн **48** нийтлэл гарсан бөгөөд тэднээс

эдийн засагч Н.Дашзэвэг 13 удаа (**27.1**%),
эдийн засагч Б.Баттөмөр 5 удаа (**10.4**%),
эдийн засагч Д.Жаргалсайхан 4 удаа (**8.3**%)

нийтлэл хэвлүүлжээ. Эдгээрийг нийтлэгдсэн тоо, аль нүүрт, нийтлэлийн зай талбай, нийтлэгчийн зургийг нийтэлсэн эсэх зэрэг шалгуураар эрэмбэлвэл дараах үр дүн харагдаж байна.





Сэтгүүлчдийн хамгийн их ач холбогдол өгч, санал бодолд нь дурдагдсан эдийн засагч, шинжээч, нийгмийн зүтгэлтэн *(Эхний 10 байрт)*



Сэтгүүлчдийн бүтээлд хамгийн олон удаа нэр дурдагдсан эхний 10 эдийн засагч










Судалгааны хугацаанд нийт 105 хүний 153 ярилцлага нийтлэгдсэн бөгөөд үүнээс Сангийн сайд С.Баярцогт 12 удаа (7.8%) ярилцлага өгч энэ төрөлд тэргүүлэв.

Удаах байрт эдийн засагч Д.Жаргалсайхан 6 удаа (3.9%), МҮЭХ-ны ерөнхийлөгч С.Ганбаатар 5 удаагийн (3.3%) ярилцлага өгснөөрөө жагсаж байна.

Ярилцлагуудаас дурдвал: **“Монголд нэн даруй нэвтрүүлэх шаардлагатай гурван төрлийн санхүүгийн үйлчилгээ байна”** /2010.02.01 Өнөөдөр/, **“Иргэдэд 625 их наяд төгрөг өгөх боломж Засгийн газарт байхгүй”** /2010.04.06 Зууны мэдээ/ зэрэг цаг үеийн холбогдолтой эдийн засгийн бодлого үйл ажиллагаа, тухайлбал Хүний хөгжил сангаас иргэдэд 70 мянган төгрөг бэлнээр тарааж байгааг шүүмжилж өөрийн байр суурийг илтгэсэн ярилцлагыг өгчээ.

The Mongolian Mining Journal нь судалгааны мэргэжлийн байгууллагуудтай хамтран уул уурхай, эдийн засгийн чиглэлээр судалгаа, санал асуулга тогтмол явуулдаг.

## ЭДИЙН ЗАСГИЙН ЧИГЛЭЛЭЭР ТӨР ЗАСГААС ГАРГАЖ БУЙ БОДЛОГО, ШИЙДВЭРТЭЙ ХОЛБООТОЙ СЭТГҮҮЛ ЗҮЙН БҮТЭЭЛД ТҮГЭЭМЭЛ ДУРДАГДСАН ЭДИЙН ЗАСАГЧ, ШИНЖЭЭЧ, НИЙГМИЙН ЗҮТГЭЛТЭН

(2010 он)





## 2008 оны Үндэсний Шилдэг сэтгүүл

Хөгжил дэвшлийнхээ шинэ зурваст тулж ирсэн Монгол Улсад уул уурхайн салбарыг түргэн хурдацтай хөгжүүлэх хойшлуулшгүй зорилт тулгарч буйг хамгаас түрүүнд соргогоор мэдэрч, салбарын хэмжээний мэргэжлийн сэтгүүлийг буй болгон нийтлэлийнхээ бодлогыг тууштай чиглүүлж Монголд орчин үеийн шинэ сэтгүүлийн үлгэр загварыг буй болгож чадсан тул уншигчид, сэтгүүл зүйн мэргэжилтэн, судлаачдын санал, дүгнэлтэд тулгуурлаж The Mongolian Mining Journal сэтгүүлийг “2008 оны шилдэг сэтгүүл“-ээр шалгаруулж өргөмжлөв.

**Монголын Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл**
**Улаанбаатар хот. 2008.12.22**




## 2012 оны МСЭ-ийн Шилдэг сэтгүүл

“Монголын Радио Телевизийн Академи”-аас санаачлан, “Монголын Сэтгүүлчдийн Эвлэл”, “Мэдээллийн Сайтуудын Ассоциаци”-аас зохион байгуулдаг “Болор үзэг” уралдаан нь сэтгүүл зүйн шилдэг бүтээлийн эзэн сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагад “Болор үзэг” өргөмжлөл хүртээн ардаршуулдаг уламжлал тогтоод цөөнгүй оныг үдэж буй.

Mongolian Mining Journal сэтгүүлийн хамт олон 2012 оны Сэтгүүлийн салбарын шилдгээр шалгарч, “Болор үзэг”-ийн эзэн боллоо.

**Улаанбаатар хот. 2012.12.25**




## Батламж

The Mongolian Mining Journal сэтгүүлийн хамт олон эдийн засаг, уул уурхайн шинэлэг хандлагыг уншигчдад төлөвшүүлэх, сэтгүүлзүйн салбарынхандаа энэ чиглэлийн шинэлэг мэдлэгийг түгчээлж хүргэхийг эрмэлзэн ажиллаж, Германы Эрдэс баялаг түүхий эдийн иж бүрэн санаачлага хөтөлбөрийн санхүүжилтээр 2015-2016 онд “Орон нутгийн сэтгүүлчдийн сүлжээ” хэмээх томоохон төслийг 16 аймгийн хэвлэл мэдээллийн 40 гаруй байгууллагын 70 орчим сэтгүүлчдийг хамруулан амжилттай хэрэгжүүлсэн тул “МСНЭ-ийн Ерөнхийлөгчийн нэрэмжит шагнал”-аар шагнасныг үүгээр батламжлав.

**Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Эвлэлийн Ерөнхийлөгч Б.Галаарид**
**2016.12.09**

# Сэтгүүл зүйн анхдагчдад батламж гардуулав

Монголын Сэтгүүлчдийн эвлэлээс Сэтгүүл зүйн салбарын анхдагчдад батламж олгодог уламжлалтай. 2012 оны арванхоёрдугаар сарын 12-ны өдрийн 12.00 цагт энэхүү хүндтэй цолыг хүлээн авах хэвлэлийн редакциуд Монголын Хэвлэлийн хүрээлэнд цуглажээ.

Монголын сэтгүүл зүйн анхдагчийн Батламжийг The Mongolian Mining Journal хүлээн авав. 2008 оны арваннэгдүгээр сарын 08-нд 001 дугаараа хэвлүүлж, Монголд хөрөнгө оруулагчдын чуулга уулзалт Discover Mongolia арга хэмжээний Мэдээллийн ивээн тэтгэгч байгууллагаар ажиллан, анхны хөрөнгө оруулалтаа босгож байсан тус сэтгүүл нь эдүгээ гадаад, дотоодод олон захиалагчтай, эрэлттэй хэвлэл болжээ.

Батламжид **“The Mongolian Mining Journal сэтгүүл нь Монголын уул уурхайн анхны хувийн мэргэшсэн сэтгүүл мөн болохыг сэтгүүлзүйн шинжээчдийн баг нотолсныг үндэс болгон Монголын үндэсний сэтгүүлзүйн түүхэнд мөнхрөх АНХДАГЧ хэмээн мэргэжлийн байгууллагын хувьд МСЭ батламжлав. МСЭ-ийн Ерөнхийлөгч Б.Галаарид, Улаанбаатар, 2012.12.12”** гэжээ.




The celebration of the 100th anniversary of National Journalism on 6 March, 2013 saw the reporting and creative departments of The Mongolian Mining Journal and its affiliate, the Progression Studio,being adjudged the best media outlet.



## 2013 оны Монголын сэтгүүл зүйн салбарын Шилдэг сэтгүүл

Монголд үндэсний сэтгүүл зүй үүсч хөгжсөний 100 жилийн ойн хүрээнд “Монголын сэтгүүл зүйн салбарын 2013 оны шилдэг”-үүдийг тодруулах ёслолын арга хэмжээг Монголын Сэтгүүлчдийн Эвлэлээс зохион байгуулсан юм. Энэхүү арга хэмжээ нь “Оны шилдэг хэвлэл мэдээллийн байгууллага” долоо, “Оны шилдэг сэтгүүлч” есөн номинацид тус тус шалгаруулалт явуулжээ.

Уул уурхайн анхны мэргэшсэн сэтгүүл Mongolian Mining Journal “Монгол улсын 2013 оны шилдэг сэтгүүл”-ээр тодров.



Үндэсний сэтгүүл зүйн 100 жилийн түүхт ойг 2013 оны гуравдугаар сарын 06-нд тэмдэглэн өнгөрүүлсэн билээ. Энэ хүндэтгэлт ойн үеэр The Mongolian Mining Journal, “Хөгжил” TV студийн сэтгүүлч, уран бүтээлчид “Хэвлэл мэдээллийн тэргүүний ажилтан” цол тэмдгээр энгэрээ мялаав.

**Монголын Сэтгүүлчдийн ерөнхийлөгч Б.Галаарид**
**2013.12.24**











# ММJ-ИЙН ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ТӨСЛҮҮД

ММJ баг ихийг амжуулжээ. Шинэ шинэ санаа, төлөвлөгөө, араас нь ундрах их ажлыг нугалахын төлөө хөдөлмөрлөсөн ачаалалтай он цаг байлаа. Салбарын мэдээллийг хүргэдэг хэвлэлийн редакцийн хувьд сонирхолтой төдийгүй үйл хэрэг, цар хүрээгээ тэлсэн олон талт ажлын ард гарчээ. Сэтгүүлийн цомхон редакцийн хөдөлмөр зүтгэлээр бүтсэн тэдгээр ажил, хэрэгжүүлсэн, хэрэгжүүлж буй төслүүдээ танилцуулж байна.

The Mongolian Mining Journal-ийн сэтгүүлчид **Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын (ОҮИТБС) тайланг** ойлгомжтой болгон мэдээлэх төслийг 2015, 2016, 2017 онд хэрэгжүүлсэн билээ.













The Mongolian Mining Journal-ийн сэтгүүлчид Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын (ОҮИТБС) тайланг ойлгомжтой болгон мэдээлэх төслийг 2015 онд хэрэгжүүлж эхэлсэн билээ.

Германы Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачилга хөтөлбөрийн захиалгаар Баянхонгор, Сэлэнгэ, Увс аймгийн түвшинд хийсэн ажлынхаа арга зүй, форматыг илүү далайцтай болгон 2016, 2017 онд үргэлжлүүллээ.










Баянхонгор, Өвөрхангай, Сэлэнгэ, Увс аймагт уул уурхайн үйлдвэрлэл явуулж буй компаниудын тухай, тэдний ирүүлсэн тайланд цогц анализ хийсэн нэг ёсны дэлгэрэнгүй судалгаа, ийм цогц харьцуулалт өмнө гарч байгаагүй бөгөөд Mongolian Mining Journal-ийн сэтгүүлчид анхлан амжилттай гүйцэтгэв.

Монголын олборлох үйлдвэрлэлийн тайлангуудад асар баялаг мэдээлэл агуулагддаг. Өдгөө тэдгээр мэдээллийг ангилж ялган, энгийн үгээр тайлбарлах, олон нийтэд хүртээмжтэй болгох, ойлгоход хэцүү нүсэр тайланг чанартай электрон мэдээллийн сангаар орлох алхам эхлүүлээд байгаа.







Энэхүү шалгаруулалтад The Mongolian Mining Journal сэтгүүлийн баг шалгарч, Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр (AMEP)-тэй гэрээ байгуулан ажилласан юм. Гурван сарын хугацаанд хэрэгжих Техникийн туслалцааны ажлын хүрээнд Уул уурхайн яам, Ашигт малтмалын газрын хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах стратеги, төлөвлөгөөний өнөөгийн байдалд дүгнэлт хийж, зөвлөмж боловсруулах, цаашид сайжруулах загвар төлөвлөгөө боловсруулах ажил хийгджээ.

Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр (AMEP)-өөс 2016 оны гуравдугаар сард Уул уурхайн яам, Ашигт малтмалын газрын олон нийттэй харилцах стратегийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх техникийн туслалцааны ажлыг гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг мэргэжлийн байгууллагуудын хүрээнд зарласан юм.

## 2016

Энэхүү төслийн үр дүнд уул уурхайн салбарын мэдээллийг олон нийтэд хүртээмжтэй хүргэх талаар алсын хараатай стратеги, төлөвлөгөө бий болж, улмаар уул уурхай ба олон нийтийн харилцаанд гүүр болох мэдээллийн ээрэг урсгалыг дэлгэрүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулна гэдэгт найдаж байна.

Ашигт малтмал, газрын тосны газраас анх удаа жилийн тайлан гаргаад байна. Уг тайланг тус газрын захиалгаар The Mongolian Mining Journal сэтгүүлийн редакцид бэлтгэн хэвлүүлсэн юм.

Тус газрын 2016 оны үйл ажиллагааны тайлан, 2017-2020 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг багтаасан баялаг агуулгатай.











# Фото архив-MMJ



Манай ашигт малтмалын салбарт хамтран ажиллах олон хувилбараар Ерөнхий сайд Путин “захиалга“ өгөх төлөвтэй байна. Хариуд нь манай улсын хөдөө аж ахуйн салбарт урт хугацааны хамтын ажиллагаа эхлүүлж болно оо гэсэн “урьдчилгаа“ өгчээ.

**2009.05.12**



**ОХУ-ын Ерөнхийлөгч Д.Медведев Монголд 2009.08.25-26**



Олон улсын атомын энергийн агентлагийн Ерөнхий захирал Мохамед Эл Барадей 2009 оны дөрөвдүгээр сарын 22-24-ний өдрүүдэд манай улсад айлчлав.



**2009.10.06 Төрийн ордны Их танхим**

Оюутолгой ордыг ашиглах хөрөнгө оруулалын гэрээнд гарын үсэг зурав.



The following is the full text of a speech by Tsakhia Elbegdorj setting out his vision for Mongolia. It was broadcast over Radio Free Asia on the morning of June 18. He was sworn in as President of Mongolia later that day.



Гэрэл зургийг Б.Рэнцэндорж /ГАММА/



**2009.10.14**

“Оросын төмөр зам” нээлттэй хувьцаат нийгэмлэгийн тэргүүн В. Якунин Монгол оронд ойр ойрхон олон удаа ирж, төмөр замын шинэ маршрут байгуулах өөрийн төслөө Монголын олон нийтэд давтан зарласаар байгаа юм.



Баяжуулах үйлдвэрийн шав тавих ёслол.
**2009.11. Ухаахудаг**



БНХАУ-ын Төрийн зөвлөлийн Ерөнхий сайд Вэнь Зябаогийн айлчлал.
**2010.06.01, Улаанбаатар**



Олон улсын атомын энергийн агентлагийн Ерөнхий захирал Юкия Амано 2010 оны 11 дүгээр сарын 1-3-ны өдрүүдэд Монгол улсад албан ёсны айлчлал хийх үеэрээ The Mongolian Mining Journal-д ярилцлага өгөв.






Элснээс өөр ээзэнгүй мэт болсон энэ хэсгийн цөлжсөн нутаг бол Өмнөговь аймгийн Баяндалай сумын Гашууны хоолой гэх газар. Монгол Улсын Засгийн газар дэлхийн уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэхийн тулд олон улсад үлгэр үзүүлж, говийн элсэн дунд хуралдаанаа хийхээр шийдвэрлэсэн нь Гашууны хоолойд ганц өдөр ч болов хүний дуу хадааж, ээзэнтэй мэт нэг өдрийг өнгөрөөсөнд энэ нутаг хур үзсэн мэт баярлан инээсэн юм .

**2010.08.27**



...БНХАУ-ын дарга Си Жинпин айлчилсны дараа Монгол улсын Хөгжлийн банк хэсэг уужуу амьсгалав. Хөгжлийн банк 580 сая ам. долларын бондын төлбөрөө 2017 онд төлнө. Хөгжлийн банк 2017 оныг амь мэнд давлаа гэхэд араас нь 2018 онд Чингис бондын 500 сая ам. долларын төлбөр гараад ирнэ.

Тэдэлгүй 2022 онд Чингис бондын үлдэх 1 тэрбум ам. долларыг төлөх хугацаа айлчлан ирнэ.

Монгол орон энэ зуны хур бороонд тааламжтай амсхийх зуураа ирэх өдрүүдийн хатуу ширүүнийг ийнхүү мэдэрч байлаа...

**August 2014.**
**MMJ № 008 (070)**



**2009.08.21 12:38**



## УИХ-ын Ээлжит бус чуулган

**2009.08-19-25**

**С.БАЯРЦОГТ**:

-Хайлуулах үйлдвэр бол хөрөнгө оруулагчаас бус Монголын талаас их хамааралтай. Одоо Оюутолгойн гэрээнд бидний хийсэн загвараар НӨАТ-ын буцаан олголтыг олгохгүй болсноор 1.7 тэрбум ам.долларыг олгохгүй болж байгаа. Харин эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хайлуулах үйлдвэр байгуулсан тохиолдолд шууд буцаан олгоно. Тэгэхээр манайд маш их ашигтай.





Economic and mining events through comics By B.Tsolmonbayar

Монголын хэвлэлийн салбарт хамгийн их үгүйлэгддэг төрөл бол комик. Олныг үгээр үл нурших, шоглол ёгтлол бүхий хурц санаануудыг зөвхөн комикийн төрөл хэвлэлийн хуудсанд үлдээдэг.




Strategic investor's tender




Will Putin close his faucet?



Hot money







New Railway construction facing obstacles






Politics and construction







Uncertainty around Tavan Tolgoi









Future of Development Bank




Mongolia in wait






# THE MONGOLIAN MINING JOURNAL